

Д.Цэдэн-Иш, А.Ариунболд, Б.Баттулга,
С.Батцоож, З.Баярмагнай, Б.Галбадрах,
Х.Доосүрэн

ДҮРСЛЭХ УРЛАГ

VIII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
8 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын
Яамны зөвшөөрлөөр хэвлэв.

Гурав дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

DDC
371.32
Д-78

Дүрслэх урлаг VIII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 8 дугаар ангийн сурах бичиг /Цэдэн-Иш Д., ба бус; Ред. Эрдэнэцог Ц. -УБ. 2015. -96х

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99962-74-46-6

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	4
1. Хавтгайн зохиомж хийх	5
2. Натюрмортын гэрэл сүүдэр, орон зайг зурааслах аргаар илэрхийлэх.	9
3. Зохиомжийн дүрэм, арга, хэрэгсэл	13
4. Өнгө ба энгийн хэлбэр дүрсээр зохиомж хийх.	16
5. Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн бүтээлтэй танилцах	20
6. Хоёр ба гурван цэгийн алслалт	26
7. Натюрморт өнгөөр зурах	30
8. Хүний биеийн ерөнхий харьцааг зөв зурж дүрслэх	34
9. Хүний хөдөлгөөнийг илэрхийлсэн таталбар, судалбар хийх	37
10. Антиква үсгийн уран бичлэгийн онцлог	40
11. Бар зургийн арга ажиллагаатай танилцаж, бүтээл хийх.	42
12. Урлагийн бүтээлээс төрсөн сэтгэгдлээ зурж, илэрхийлэх	46
13. Монгол зургийн дүр, дүрслэлийн онцлог	50
14. Уран дархан, арьсан болон эсгийн урлагтай танилцах	54
15. Монгол бичгээр эвхмэл болон уран бичлэг бичих аргад суралцах	56
16. Дүрслэх урлагийн чиг хандлагыг ойлгож мэдэх	60
17. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлтэй танилцах	69
ЦАХИМ ХАЯГ:	78
НОМ ЗҮЙ	79

ТАНИХ ТЭМДЭГ



Мэдрэн ойлгох



Сонирхон судлах



Бүтээн хөгжих



Илэрхийлэн
харилцах

ӨМНӨХ ҮГ

Монгол улс хүүхэд бүрийг хөгжүүлэх, тэдний суралцах, хөгжих, адил тэгш эрхийн баталгааг хангах, хүртээмжтэй, чанартай ерөнхий боловсролын үйлчилгээ бий болгох суурь зарчимд тулгуурласан бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж байна. Сурагчдад урлагийн гоо сайхны мэдрэмжтэй, соёлч боловсон ёс зүй, бие бялдрын өв тэгш байдал чухалчилсан амьдрах чадвар эзэмших, насан туршдаа боловсрол эзэмших боломж нээлттэй байна.

2014 онд батлагдсан төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод “Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмших үе шат хэмээн үзэж хөгжүүлнэ” гэж заасан.

Дүрслэх урлагийн хичээлээр тухайн даалгаврыг гүйцэтгэх явцад сурагчид зурах, дүрслэх, барих, наах, чимэглэх, зохиомжлох, бүтээх, мэдрэмж, таашаал авч, ургуулан бодох, сэтгэх, асуудал шийдвэрлэх, өөрийгөө илэрхийлэх зэрэг чадваруудыг амьдралаас урган гарсан бодит дүрслэлээр илэрхийлж суралцана.

Сурагчид зурах арга барилд суралцаж, Мэдрэх, ойлгох, Сонирхон судлах, Бүтээх, хөгжих, Илэрхийлэх, харилцах, дүн шинжилгээ хийх чадвар эзэмшихийг чухалчилна. Үүнд:

- Мэдрэх, ойлгох: Дүрслэх урлагийн хэрэгсэл ашиглаж тэдгээрийн талаар ойлголтоо баяжуулж, урлагийн хэл, нэр томъёог бүтээлээр дамжуулан мэдрэх, мэдэх үйл ажиллагаатай холбон дүрслэн бодож, сэтгэж, эргэцүүлэн хэрэгжүүлнэ.
- Сонирхон судлах: Дүрслэх урлагийн бүтээл болон уран бүтээлчийн талаар мэдээлэл цуглуулах, уншиж судлах, даалгавар, дадлагын ажлын хэлбэрээр харьцуулах зэргээр дүн шинжилгээ хийнэ.
- Бүтээх, хөгжих: Зураг зурах, дүрслэх, зохиомжлох, уран зураг унших зэргээр бүтээхийн сайхныг мэдрэх, турших, өөрийн санаа бодол, мэдрэмж, сэтгэн бодох чадвараа харуулах, хувирган өөрчилж сайжруулах, өөрийгөө илэрхийлэхэд чиглэнэ.
- Илэрхийлэх, харилцах: Өөрийн зурсан, барлан дардасласан, нааж, шигтгэж бүтээсэн, фотогоор зохиомжилсон, эвхэж бичсэн зэрэг бүтээлийн үр дүнг таниулах, харилцан ярилцах, тайлбарлах, сэтгэгдлээ илэрхийлэх, туршлага солилцох, анги, сургууль, орон нутгийн хэмжээнд үзэсгэлэн гаргах, үнэлж дүгнэх зэргээр суралцана.

Сурагчид аливаа юмс, үзэгдэл, урлагийн бүтээлийг танин мэдэх арга барилтай, өөрийн авьяас, гоо сайхны мэдрэмжээ бүтээлчээр илэрхийлж, хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй иргэн болж төлөвших болно.

ХАВТГАЙН ЗОХИОМЖ ХИЙХ





Эдгээр бүтээлийг ямар аргаар зурсныг ажиглаарай.



Зураг 1. С.Батцоож “Олдвор”, “Нутгийн зүг” 2015 сэдэвт цэгэн зураг






Зураг 2. Австралийн уугуул иргэдийн уламжлалт уран зураг



Зураг 3. Зураас ашиглан хийсэн зохиомж




Дараах зургуудыг ажиглаж цэг, толбоор зохиомжилсон ажлуудын онцлог ялгааг нэрлэнэ үү. (3 дугаар зураг)



Зураг 4. Цэгээр зурсан хавтгайн зохиомж




Зураг 5. Толбоор хийсэн хавтгайн зохиомж



Зураг 6. Шулуун болон муруй зураасаар хийсэн хавтгайн зохиомж

Цэгийн том жижиг, нягт болоод сийрэг байдлаас шалтгаалан бидний өдөр тутам хэрэглэдэг телевиз, гар утас, хэвлэл, сэтгүүлийн дүрслэл бий болдог бөгөөд түүний нэгээхэн хэсгийг томруулан харахад ямар сонин дүрс харагддаг болохыг ажиглаарай (Зураг 7).



Зураг 7. Дүрс цэглэл болж харагдах тохиолдол

Амьтдын толбо, зурааслал нь ямар өнгө, хэлбэр дүрстэй байгааг нэрлэж, хооронд нь харгалзуулаарай (Зураг 8).



Зураг 8. Амьтдын биеийн толбо ба зураасан дүрслэл




1. Сурагч бүр 10x10 см-ийн хэмжээтэй өнгийн цааснууд бэлтгэнэ. Эхний цаасан дээр том, жижиг цэгийг цацраг, дугуй болон долгиолсон байдлаар эрэмбэлүүлэх эсвэл чөлөөт байдлаар зохиомжлон өрж зурах, наах.

2. Амьтдын толбо, эдлэлийн хээ чимэглэлийг тунгалаг слайд дээр хар эсгий балаар зурна. 10x10 см-ийн хэмжээтэй өнгийн цааснуудаа слайд дээр нааш цааш гүйлгэн үзэж зөв, зохимжтой харагдаж буй хэсгээ гэрэлтүүлэн цаасан дээр буулган авч тохирох өнгөөр будах, наах байдлаар зохиомж хийнэ (Зураг 9).




Зураг 9. Толбоор хавтгайн зохиомж хайх дараалал


3. Зураасаар зохиомж хайхдаа бараан өнгийн цаасан дээр цагаан зураасаар, цагаан болон тод гэрэлтэй өнгийн цаасан дээр хараар гэх мэт эрс тэс өнгийн ялгарал сайтай зурагт үзүүлэн үзүүлнэ. Сурагчид өөрсдийн хүссэн зурааслалаар 10x10 см-ийн хэмжээтэй цаасан дээр зохиомжлон зурна. Зураас нь шулуун, муруй, дугуй, долгиолсон зэрэг ямар ч байж болно (Зураг 10).



Хар өнгийн дэвсгэр дээр цагаан өнгийн зураасаар зурсан байдал



Цагаан өнгийн дэвсгэр дээр хар өнгийн зураасаар зурсан байдал



Зураасыг дугуйруулан зохиомжилсон байдал



Тодорхой дүрсийг хүрээлэх байдлаар зураасыг дахин давтаж хийсэн зохиомж

Зураг 10. Зураасны төрөл ашиглан хийсэн хавтгайн зохиомж



Багууд өөрсдийн зурсан 10x10 см-ийн хэмжээтэй 3 ширхэг ажлаа 20x40 см-ийн хэмжээтэй том цаасан дээр цэг, толбо, зураас гэсэн дарааллын дагуу тэгш, зохиомжтой нааж, бусад багийнхандаа үзүүлэн, ярилцаарай.

Өөрсдийн дуртай нэг амьтны гэрэл зураг сонгон авч түүний толбыг дуурайлган 10x10 см хэмжээтэй 2 өөр өнгийн цаасан дээр 2 өөр зохиомж дүрслэлтэй бүтээл хийж, гэрэл зургийн хамт зургийн дэвтрийн цаасан дээр нааж ирнэ. Бүтээлийг өнгийн хуулга, цаас ашиглан наах, компьютерын зураг боловсруулах программ дээр хийж болно (Зураг 11).



Зураг 11. Амьтны толбоор зохиомж хийх аргачлал

НАТЮРМОРТЫН ГЭРЭЛ СҮҮДЭР, ОРОН ЗАЙГ ЗУРААСЛАХ АРГААР ИЛЭРХИЙЛЭХ



Зураг 12. Шилэн сав



Шилэн сав бодит мэт харагдаж байгаагийн нууц юунд оршиж байна вэ?

Эд юмс дээр туссан гэрэл сүүдрийн хамгийн бага ялгааг илэрхийлэх нь сурагчаас их ур чадвар, мэдрэмж, туршлага шаарддаг. Энэ бага ялгаа, шилжилтийг илэрхийлж сурахын тулд эхлээд зурааслалын аргад суралцдаг.

Зурааслалын аргыг сайн эзэмшсэнээр төрөл бүрийн биетийн гадаад шинжийг илэрхийлж сурна.



Эд юмсын гэрэл сүүдрийг төрөл бүрийн зурааслалын аргаар илэрхийлж болно.

Сурагчид натюрморт зурахдаа хэдэн төрлийн зураас ашигласныг сайтар ажиглаарай. Зураасны чиглэл, хүнд хөнгөн зурлага хэсгүүдийн талаар ярилцана уу.

Зургийн аль нэг хэсгийг сонгон авч, томруулан зурж үзнэ үү. Зурахдаа зураасыг нь аль болох адил дуурайн зураарай. Тухайн эд зүйл нь ямар энгийн биеттэй ижил хэлбэртэй болохыг олж хараад энгийн биетийн гэрэл сүүдрийг зурж байсан туршлагаа ашиглаарай.




Зураг 13. Ваартай натюрморт



Зураг 14. Янз бүрийн зүйлээс бүтсэн натюрморт



Бөмбөрцгийн гэрэл сүүдрийг алимны гэрэл сүүдэртэй харьцуулан харж, ижил болон ялгаатай талуудыг ярилцаж дүгнэлт гаргаарай. Алим дээр туссан гэрлийн гялаан, гэрэлтэй хэсэг, сүүдэртэй хэсэг, өөрийн сүүдэр, ойсон гэрэл, унасан сүүдрийн хэсгүүдийг тодорхойлон гадаргуугийн ялгаатай байдлаас хамааран гэрэл сүүдрийн хуваарилалт хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглаад зураарай.




Зураг 15. Эргэлтийн гадаргуутай натюрморт

Зурааслах аргыг сайн эзэмшсэн үед натюрмортыг үзгээр, балаар гэх мэт баллуур хэрэглэхгүйгээр зурах чадвартай болдог. Энэ натюрмортыг үзгээр зуржээ.


Натюрмортыг зохиомж, байгуулалт, гэрэл сүүдэр гэсэн гурван үе шаттай зурдаг.

Гэрэл сүүдрийг зурааслалаар илэрхийлснээр эд юмсын шинж чанар, орон зай тодорхой болдог. Алслалтын хуулийн дагуу наана байгаа эд зүйлийг тод, цаана байгааг нь бүдэг зурна. Ингэснээр зураг илүү орон зайтай болж харагддаг. Мөн хатуу биетийг нягт жигд зураасалдаг бол зөөлөн даавуун зүйлсийг арай сийрэг хөнгөн зураасалж зурдаг.



Зураг 16. Натюрморт зурах дараалал

Натюрмортыг ямар дарааллаар зурсныг ажиглаарай. Аль нэг биетийн гэрэл сүүдрийг ялгахдаа тэр биетийг ганцааранг нь дуустал зуралгүй бусад биетээ гэрэл сүүдрийн ялгамж хүнд, хөнгөний харьцаатай нь харьцуулан зурсан байна. Натюрморт зурах дээрх дарааллыг баримтлан зурж сураарай.




Зураг 17. Гэрэл сүүдрийн ялгамж



Зурааслах аргаар гэрэл сүүдрийг илэрхийлэн гурван хэмжээст биет зураг зурж болно. Зурж сурахын тулд эд юмсын гэрэл сүүдрээр орон зайг сайтар илэрхийлж сурсан байх шаардлагатай.



Доорх зурааслалын дасгалыг дуурайн хийгээрэй.



Зураг 18. Зурааслалын ялгамж

ЗОХИОМЖИЙН ДҮРЭМ, АРГА, ХЭРЭГСЭЛ



Зохиомж нь дан ганц урлагийн бүтээлд байдаг бус бидний өдөр тутам хэрэглэдэг бүхий л зүйлсэд тусч байдаг. Үүний шалтгаан нь нүдэнд харагдах бүх зүйлсийг хүн өөрийн оюун ухаандаа зохиомжлон бодож, дүрслэн зурж, түүнийгээ хийж бүтээдэгт оршдог. Зохиомж нь тодорхой дүрэм, арга, хэрэгсэлтэй байдаг. Суралцагчид зохиомжлох чадвараа хөгжүүлэхийн тулд энгийн хэлбэр дүрс, өнгөөр төрөл бүрийн зохиомж хийдэг. Ингэснээр хэлбэр дүрсүүд хоорондоо яаж зохицдог, өнгүүд бие биедээ хэрхэн нөлөөлдөг болохыг таньж зохиомжийн олон төрлийн дүрэм, аргад суралцдаг.



Зураг 19. Орчин үеийн дизайн дахь зохиомжийн шийдлүүд

Жишээлбэл Malevich-ийн хийсэн зохиомжийг сурталчилгааны бүхий л зүйл дээр хэрэглэсэн нь гайхалтай сайхан зохицдог.



Доорх жишээг тайлбарлан ярилцаарай.



Зураг 20. Malevich-ийн зохиомжоор хийсэн сурталчилгааны иж бүрдэл



Дараах дүрсийн зохиомжид хэдэн дүрс давтагдаж байгаа, ямар өнгө орсон болохыг судалж, хоорондоо хэрхэн зохицож байгааг ярилцаарай (Зураг 21).



Зураг 21. Дүрс ашиглан хийсэн уран бүтээлийн зохиомж



1. Энэ бүтээлийн дүрсийн зохиомжийг ажиглаж дан ганц тэгш өнцөгт дүрсээр хэчнээн зохиомж хийж болохыг ярилцаарай (Зураг 22).

Зураг 22. Тэгш өнцөгт дүрс ашиглан хийсэн уран бүтээлийн зохиомж




Зураг 23. Тэгш өнцөгт цааснууд

2. 10x10 см-ийн хэмжээтэй цаасан дээр өгөгдсөн тэгш өнцөгт дүрс бүхий өнгийн цааснуудыг янз бүрийн хэлбэртэй болгон зохиомжлон өрж, хамгийн зөв харагдаж байгаа өрөлтийг нааж гүйцэтгэнэ. Наахдаа хүнд хөнгөн өнгийг ээлжлэн наах, том дүрс дотроо жижиг дүрсээ оруулах, эсвэл дунд зэргийн дүрсүүдээ хооронд нь зөрүүлэх зэргээр наана (Зураг 24).



Зураг 24. Цаасан зохиомж

3. Багуудад ухаж бэлдсэн 1-5 ширхэг том, жижиг тэгш өнцөгт бэлэн дүрс (шаблон) өгч цаасан дээр янз бүрийн хэлбэр гаргах эрэл хийн, нааж болно. Бэлэн болсон зургаа өнгийн цаас, хуулга ашиглан өгсөн даалгаврын дагуу өнгө зохицуулан дүрслэн зохиомжилж болно.








Зураг 25. Өнгөт цаасан зохиомж

Баг тус бүр дууссан ажлаа том цаасан дээр нааж, ангийн хананд өлгөнө. Багууд яагаад тус өнгийг сонгож авсан, дүрсийн давталтаа зохиомжийн хуулийн дагуу хэрхэн авсан талаар тайлбарлан өгнө. Тус ажлуудаас сурагчдад зөвхөн тэгш өнцөгт дүрсээр гэхэд л хэчнээн олон хэлбэр дүрс үүсгэж, ямар өнгийг хооронд нь зохицуулж болдог вэ гэдгийг хүүхэд бүрийн хийсэн ажлууд дээр тайлбарлан, зохиомжийн төв, тэнцвэр, нэгдэл, хэмнэл, давтамжийн талаар ярилцана (Зураг 25).



Хүснэгтэд байгаа асуултын тэмдгийн оронд тохирох зохиомжийн хэрэгслүүдийг нөхөж хэлнэ үү (Зураг 26).


ЗОХИОМЖИЙН ХЭРЭГСЭЛ				
?	?	?	?	?
				

Зураг 26. Зохиомжийн хэрэгсэл

ӨНГӨ БА ЭНГИЙН ХЭЛБЭР ДҮРСЭЭР ЗОХИОМЖ ХИЙХ




Бидний амьдралд өнгө яагаад чухал байдаг вэ? Өнгийг бид яагаад ялгаж хардаг вэ?



Зураг 27. Бидний эргэн тойронд байгаа бүхий л зүйлсийн гайхамшигт өнгө



Бид нарны гэрлийн тусламжтайгаар аливааг харж, тэдгээрийн өнгийг ялган таньж байдаг. Цагаан гэрлийг гурвалжин линзээр дамжуулан гаргахад тус гэрэл задарч, бидний харж байдаг өнгүүдийг үүсгэдэг (Зураг 28). Заримдаа бид энэхүү үзэгдлийг солонгын тусламжтайгаар хардаг (Зураг 29).




Зураг 28. Нарны гэрлийг линзээр нэвтрүүлэн өнгө задлан харуулж буй байдал



Зураг 29. Байгалийн солонго

Нарны цагаан гэрлээс үүссэн өнгүүд нь тойрогт эрэмбэлэхэд битүү тойрог үүсгэн бие биедээ алгуур уусаж, маш олон өнгө бий болгож байдаг. Түүнийг 12, 24, 48 гэх мэт хэдэн ч өнгөд хувааж болох бөгөөд хэдий чинээ их хуваана тэр


чинээгээрээ өнгийн ялгамж нь улам нарийсаж байдаг. Үүнийг өнгийн дугуй гэж нэрлэдэг (30 дугаар зураг). Өнгийн дугуйгаас эсрэг, ойролцоо, эрс тэс өнгүүд болон хүйтэн, дулаан өнгүүдийг ялган харахад хялбар байдаг (Зураг 31).



Зураг 30. Өнгийг хувааж өнгийн дугуй үүсгэсэн байдал



Зураг 31. Эсрэг өнгүүдийн байрлал




Зураг 32. Эсрэг, ойролцоо, эрс тэс өнгүүдийн байрлал



Доорх дүрсийн зохиомжид хэдэн дүрс давтагдаж байгаа, хэдэн өнгө орсон, ямар өнгө зонхилж байгаа, хоорондоо хэрхэн зохицож байгааг ярилцаарай (Зураг 33).

Нэг дүрсийн зохиомжоо хүйтний ойролцоо, хүйтний эрс тэс, дулааны ойролцоо, дулааны эрс тэс гэх мэтээр өнгийн дугуйгаа ашиглан ямар ч байдлаар зохиомж хийхэд хялбар болдгийг зургаас харж болно.






Зураг 33. Эрс тэс өнгийн зохиомж



1. Нэг багт 4 сурагч байхаар хуваагдаж, өгсөн дүрсийн бэлдцийг ашиглан 10x10 см-ийн хэмжээтэй цаасан дээрээ дүрсийн давталт хийх бөгөөд баг бүр өөр загвар гаргасан байх шаардлагатай (Зураг 34).



Зураг 34. Нэг загвар ашиглан давталт хийсэн байдал.

2. I баг дулааны ойролцоо (Зураг 35), II баг дулааны эрс тэс (36 дугаар зураг), III баг хүйтний ойролцоо (Зураг 36), IV баг хүйтний эрс тэс (Зураг 38) өнгөнд зохиомж хийнэ. Нэг багийн 4 гишүүд 1-4 давталт хийхдээ нэг дэх сурагч нэг давталт, хоёр дахь сурагч хоёр давталт гэх мэтээр 10x10 см-ийн цаасан дээрээ тус бүрдээ дөрвөн ялгаатай байдлаар зохиомжийн хуулийн дагуу гүйцэтгэнэ (Зураг 34).



Зураг 35. Дулааны ойролцоо өнгө



Зураг 36. Дулааны эрс тэс өнгө



Зураг 37. Хүйтний ойролцоо өнгө



Зураг 38. Хүйтний эрс тэс өнгө



Баг тус бүрийн хийсэн ажлыг 15х50 см-ийн хэмжээтэй цаасан дээр хэвтээ байдлаар давталтын тооны дарааллаар нааж, ангид байрлуулна. Багууд яагаад тус өнгийг сонгож авсан, дүрсийн давталтаа зохиомжийн хуулийн дагуу хэрхэн авсан талаар тайлбарлан зохиомжийн төв, тэнцвэр, нэгдэл, хэмнэл, давтамжийн талаар ярилцаарай.



Зохиомжийн ажлаа компьютер дээр дахин зурж, сайжруулан түүнийгээ аяга, цамц, утасны гэр зэрэг ахуйн хэрэглээний юмс дээр хэрхэн буулгаж болохыг туршаарай.

СЭРГЭН МАНДАЛТЫН ҮЕИЙН ДҮРСЛЭХ УРЛАГИЙН БҮТЭЭЛТЭЙ ТАНИЛЦАХ



Сэргэн мандалт буюу Рениссанс гэдэг нь “Шинээр төрсөн” гэсэн утгатай. Дундад зууны үеийн Европын соёл урлагийг шинэчлэн сэргээж шинэ цаг үеийн соёл урлаг бий болсон үе юм. Энэ үеийн үргэлжилсэн хугацааг XIV-XVI зуун гэж үздэг. Англи, Испани, Итали улсуудад түлхүү хөгжсөн Сэргэн мандалтын үеийн гол үзэл баримтлал нь “Ертөнцийн төвийг хүн гэж үздэг”-т оршдог. Хүний оюун ухаан, гоо сайхан, бурханлаг чанарыг эрхэмлэж урлагийн бүх төрөлд тусган харуулдагт энэ үеийн онцлог оршдог.

Пьетро Перужино. (1446-1523) Италийн Сэргэн мандалтын эхэн үеийн нэрт зураач.


Түүний “Түлхүүр гардуулж өгсөн нь” ханын зургийн бүтээлээс тухайн үеийн Итали орны урлагийн төв болсон Флоренц хотын байдал, хүмүүсийн хувцаслалт, дүр төрх, амьдралын хэв шинжийг харж болно.




Зураг 39. Пьетро Перужино



Зураг 40. Пьетро Перужино. “Түлхүүр гардуулж өгсөн нь”
1482. Ханын зураг, темпер. Сикстиний сүм. Ром



Зураг 41. Леонардо да Винчи.
(1452-1519) Италийн
эрдэмтэн, математикч,
инженер, зохион бүтээгч,
анатомич, зураач, сийлбэрч,
уран барималч, архитектурч,
хөгжимчин ба зохиолч



Зураг 42. Леонардо да Винчи. “Джоконда”
(1503-1519). Модон самбар, тос. 76.8x53см.
Лувр, Парис




Зураг 43. Леонардо да Винчи.
“Мадонна Литта”. 1491. Зотон,
темпер. 42x33 см. Эрмитаж,
Санкт-Петербург



Мона Лиза нь Леонардо да Винчийн зурсан, XVI зууны хөрөг зураг юм. Энэ зураг нь одоо Парисын Луврын музейд хадгалагддаг, “Гунигтайхан харж, учиртай инээмсэглэх” энэ бүсгүйн хөрөг зураг хүн төрөлхтний уран зургийн түүхэнд хүндтэй байр суурь эзэлдэг. Мона Лизагийн алдрын гол үүдэл нь Леонардо да Винчийн авьяас юм. Жоконда бол их мастерын нэрийн хуудас. Сэргэн мандалтын үеийн бүх ололт энэ зурагт нэгтгэгдэж өндөр түвшинд бүтээгдсэн билээ. Энд байгаль ба хөргийн зохицол, бүсгүйн хагас хөндлөн суусан байрлал, үзэгчид хандсан харц, пирамид загварын зохиомж бүгд байгаа. Гэрэл сүүдэр нь тод ялгамжтай боловч хэлбэр илэрхийлсэн нь уян зөөлөн зурлага ерөнхий бор ногоондуу дулаан өнгө нийцэл нь зураачийн сэтгэлгээг илтгэнэ. Их мастерын зургийн бичлэг, зурах арга ажиллагаа ч илэрхий харагддаг. Мона Лиза Европын урлагт сэтгэл зүйн хөргийн шинэ төрлийн эхлэлийг тавьсан билээ. Аугаа их мастер

энэ бүтээлээ туурвихдаа гэрэл сүүдрийн тод ялгарал, зөөлөн хөг аялгуу, хөдөлгөөнгүй зогсонги чанар, өөрчлөлт хувиралт, сэтгэл зүйн нарийн мэдрэмж, шилжилт зэрэг уран сайхны бүх арга хэрэгслийг ашигласан байна.



Зураг 44. Микеланджело Буонарроти.
(1475-1564) Италийн зураач, сийлбэрч, уран
барималч, архитектурч, зохиолч



Зураг 45. Микеланджело. “Пьета”. 1499.
Цагаан гантиг. Өндөр нь 174 см. Ариун
Петрийн сүм. Ватикан



Зураг 46. Микеланджело. “Давид”. 1504.
Цагаан гантиг. Өндөр нь 5.17 м. Флоренцийн
дүрслэх урлагийн академи. Итали

Микеланджело Буонарротигийн бүтээсэн уран баримлын бүтээлүүд дотроос “Давид” нь хамгийн шилдэг нь гэж үздэг. Давид бол эртний Грекийн домогт баатар эрийн дүр бөгөөд энэ сэдвээр сэргэн мандалтын үеийн олон уран барималчид бүтээл хийсэн байдаг. Хүний гоо сайхныг магтан дуулж байсан сэргэн мандалтын үеийн урлагт Микеланджелогийн бүтээсэн Давид нь эр хvний бие галбирын сонгодог загвар болсон хэмээн тооцогддог. Давид баруун гараа атган, зүүн мөрөн дээрээ дүүгүүрийн оосор тохож, биеийн хүндийг баруун хөлөндөө төвлөрүүлэн зогссоноор түүний булчин шөрмөс зангиран хүч чадлыг илтгэх ажээ. Асар том гантиг чулууг сийлж урласан энэ баримал 5 м 17 см өндөр гэдэг.



Зураг 47. **Рафаэль Санти**. (1483-1520) Италийн агуу уран зураач, графикч, архитектор, Умбрын уран зургийн сургуулийн төлөөлөгч




Зураг 48. Рафаэль Санти. “**Сикстиний Мадонна**”. 1512. Зотон, тос. 265x196 см. Дрезден, Герман

Сикстиний Мадонна


Энэхүү бүтээлд Мадонна эх дагина хүү Христийг тэвэрсээр үүлэн дээгүүр алхан бууж ирж байгааг дүрслэн харуулсан байдаг. Тэднийг гэгээн Сикстус, гэгээн Варвара нар угтан авч хүндэтгэл илэрхийлж байгаа бол тэдний доод хэсэгт сахиусан тэнгэрүүдийг дүрсэлжээ. Рафаэлийн энэхүү бүтээл нь түүний зурсан сүүлчийн Мадонна байсан ба зохиомжийн сүрлэг байдал үндсэн өнгүүдийг ягаавтар, саарал дэвсгэртийн наана хослуулсан сийрэг зөөлөн бичлэгээр гадна хэсгийг сарниулсан зэрэг нь сэргэн мандалтын уран зургийн хөгжилд шинэлэг арга ажиллагааны гайхамшигт бодит байдлаараа түүхэн давтагдашгүй бүтээл болж чаджээ.



Зураг 49. Рафаэль Санти. “**Афиний сургууль**” 1511



Сэргэн мандалтын хожуу үе буюу Венецийн урлагийн оргил үед уран зурагт алтлаг дулаан өнгө зохицол гол хэсгийн зуралтыг туслах хэсгээс бийрийн чөлөөтэй таталтаар ялгаатай зурж, урд үед зонхилж байсан хэт төгс зуралтаас ангижирч тодорхой дүрмийн биш чөлөөт арга ажиллагааг нэвтрүүлснээрээ онцлог билээ.




Зураг 51. Тициан. “Залбирч буй Мария Магдалина”. 1565. Зотон, тос. 119х98 см




- Зураач Тициан “Залбирч буй Магдалина” зурагт ямар үйл явдлын тухай дүрсэлсэн байгааг таамаглал дэвшүүлэн ярилцаарай.
- Зургийн зохиомж сэргэн мандалтын үеийн өөр ямар алдартай уран зурагтай төстэй байна вэ?
- Зургийн өнгө, гэрэл сүүдэр, арын хэсгийн дүрслэл нь зургийн утга санаатай ямар уялдаатай байна вэ?
- Энэ бүтээл сэргэн мандалтын хэдий үед хамаарах вэ?
- Тициан уран зургийн бичлэг өнгө зохицолд ямар шинэчлэлийг авчирсан бэ?

Тэрээр Сэргэн мандалтын үеийн бусад зураачдын адил хөрөг зураг, Христийн амьдралын сэдвээр зурдаг байсан бөгөөд Эртний Грекийн үлгэр домгийн сэдвээр зурсан “Венера мэндэлсэн нь”, “Хавар” бүтээлүүд нь дэлхийн дүрслэх урлагийн түүхэнд давтагдашгүй суут бүтээл болж чадсан юм.

Сандро Боттичелли хүний биеийн сайхныг дүрслэхдээ зориуд хэтрүүлэн зурсан яруу хөдөлгөөнөөр илэрхийлдгээрээ онцлогтой.



Зураг 52. Сандро Боттичелли (1445-1510) Италийн суут зураач, Флоренцийн уран зургийн сургуулийн төлөөлөгч



Зураг 53. Сандро Боттичелли. “Венера мэндэлсэн нь”. 1486. Зотон, темпер. 172x279 см. Уфици. Флоренц




- “Венера мэндэлсэн нь” бүтээлийн Венерагийн дүр ямар утга агуулгатай болохыг судлан уншаарай.
- Сандро Боттичеллигийн “Хавар” бүтээлийн талаар сонирхон судлаарай.

ХОЁР БА ГУРВАН ЦЭГИЙН АЛСЛАЛТ




Нэг, хоёр ба гурван цэгт алслалт зурах асуудал шийдвэрлэхийн тулд зургууд дээр ярилцах, асуудлаа ойлгох, яаж судлах талаар ярилцах. Нэг цэгт алслалт зурах, харааны түвшин, байгуулалт зэрэг өмнөх мэдлэгийг сэргээн санах үйл ажиллагаанд дараах зургуудыг ашиглаж болно.



Зураг 54. Нэг цэгт алслалттай зурах арга

Хоёр цэгийн алслалт


Хоёр цэгийн алслалтаар барилга, гудамж зэрэг том хэмжээтэй зүйлсийг зурж болно (Зураг 55).



Зураг 55. Хоёр цэгт алслалт зурах арга




Нэг цэгт алслалттай зурах аргад үндэслэн хоёр цэгт алслалттай зурах аргад суралцана. Аливаа биет харааны түвшний шугамаас дээш, харааны түвшинд давхцах, харааны түвшнээс доош гэсэн гурван байрлалд алслалттай харагддаг.



Зураг 56. Хоёр цэгт алслалттай аргаар зурсан номын харагдах байдал




Тэгш өнцөгт түвшний шугамын аль хэсэгт хэрхэн харагдаж байгааг тогтоон ярилцах. Байгуулалтын шугамуудыг ажиглан судлах. Тэгш өнцөгтийн байгуулалтын шугам А,В хоёр цэгт очиход хэрхэн дүрслэгдэж байгааг судална.



Зураг 57. Хоёр цэгт алслалттай зурах аргаар зурсан тэгш өнцөгт

VIII АНГИ

Сурагчид өөрсдийн сонирхсон дүрсийг хоёр цэгт алслалттай зурна. Тэгш өнцөгт биетийг зургийн хавтгайд өнцөгөлсөн чиглэлээр байрлуулбал зураг дээр хоёр цэгт алслалттай зурагдана.



Зураг 58. Хоёр цэгт алслалттай зурах аргаар зурсан зургууд

Гурван цэгийн алслалт



Том овор хэмжээтэй өндөр зүйлс, барилга байгууламжийг ойрын зайнаас доороос дээш эсвэл дээрээс доош харсан байдлаар зурахад гурван цэгт алслалтын байгуулалт хийдэг. Ажиглалт зөв хийх нууц нь тухайн зүйлийг зурах харааны түвшний цэг болон байгуулалтын шугамыг тодорхойлох асуудал юм. Үүнийг сурагчид судлах нь чухал. Хоёр цэгт алслалт зурах аргыг суурь болгон гурван цэгт алслалт зурах аргад суралцаарай.




- Өндөр барилгын фото зурагт ажиглалт хийх
- Өндөр барилгыг доороос дээш харахад үүсэх алслалтыг ажиглах
- Өндөр барилгыг гурван цэгт алслалтаар зурсан зурагт ажиглалт хийх.


(Зураг 59)



Гурван цэгт алслалт хэрхэн зурах аргын талаарх судалгаандаа үндэслэн, ярилцан тайлбарлаад зурна.




Зураг 59. Өндөр барилгуудыг доороос харсан байдал



Зураг 60. Гурван цэгийн алслалттай зурсан зураг



Нэг, хоёр, гурван цэгийн алслалтын байгуулалтын ялгааг харьцуулан харж харагдах байдлын ялгааны талаар ярилцаарай.



Зураг 61. Нэг, хоёр, гурван цэгийн алслалттай зурах аргууд

НАТЮРМОРТ ӨНГӨӨР ЗУРАХ



Дараах зургийн өнгө, арга ажиллагааг сайтар ажиглаарай (Зураг 62).



Зураг 62. Лийртэй натюрморт

Натюрмортыг харандаагаар зурсан туршлага дээрээ тулгуурлан өнгөөр зурна. Эхлэн суралцагчдын хувьд натюрмортыг усан будаг, гуашаар зурах нь зохимжтой. Лийртэй натюрмортыг усан будгаар зурсан байна. Усан будгаар зурсан зургийн өнгө цэвэр, тунгалаг, уусалт нь гоёмсог харагддаг. Усан будгаар ингэж зурж сурахын тулд багагүй туршлага хэрэгтэй. Түүнчлэн өнгө, будгийн талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй байх шаардлагатай. Дулаан өнгө ойр харагддаг бол хүйтэн өнгө хол харагддаг.

Өнгийн дугуй дээрх эсрэг байршилд орших өнгүүдийг хооронд нь хольж болохгүй. Ийм өнгүүд нь бие биеэ тодотгож сайхан зохицдог хэдий боловч хооронд нь холивол өнгө хиртдэг. Өнгө хиртэнэ гэдэг нь хооронд нь хольсон өнгүүдээс ямар нэг шинэ өнгө үүсэхгүй шороо мэт өнгөтэй болохыг хэлдэг.



Нэг өнгийн дагнаасыг усан будгаар зурж үзээрэй (Зураг 63). Ингэхдээ цайвраас бараан өнгө рүү, өмнөх өнгөө бүрэн хатсан хойно нь давхарлан будах замаар зурна.



Зураг 63. Усан будгаар 1 өнгийн тон (өнгийн ялгарал) илэрхийлэх дасгал



а. Хар зураг



б. Суурь өнгө бичсэн байдал



в. Унасан сүүдэр бичсэн байдал



г. Зурж дууссан байдал



Зураг 64. Жимс зурах дараалал



Натюрморт зурсан дарааллыг ажиглаарай. Усан будгаар эд юмсын гэрэл сүүдрийг илэрхийлэхдээ нэг өнгөөр дагнаас хийсэн аргын адилаар хамгийн цайвар, гэрэлтэй, хөнгөн өнгөөс эхлэн зурна. Эхний суурь өнгө бүрэн хатсаны дараа хүнд өнгийг тухайн зүйлийн сүүдэртэй хэсэгт давхарлан бичнэ. Харандаагаар зурж байгаа үед гэрэл сүүдрийг давхарлан зураасалдаг бол, бийрээр зурж байгаа үед гэрэл сүүдрийг давхарлан бичнэ гэж ярьдаг. Зурааслахдаа гадаргуугийн хэлбэрийн дагуу хийдэг шиг бичилт хийхдээ гадаргуугийн хэлбэрийг дагуулна. Бичилт хийх нь өнгөөр гэрэл сүүдэр гарган биеийн хэлбэр илэрхийлэх үндсэн арга юм.




Улаан өнгийн уусалтыг усан будгаар хийж туршаарай (Зураг 65).

Зураг 65. Усан будгаар 1 өнгийн уусалт гаргах дасгал



а. Фото зураг



б. Хар зураг



в. Суурь өнгөөр бичсэн байдал



г. Зурж дууссан байдал

Зураг 66. Хүнсний зүйл гуашаар зурах дараалал



Натюрмортыг гуашаар зурах дараалал нь усан будгаар зурахаас ялгаатай. Усан будгаар зурахад эд юмсын гэрэлтэй хэсгийг эхэлж бичдэг бол гуашаар зурахад ихэвчлэн сүүдэртэй хэсгийн өнгийг эхэлж бичээд, гэрэлтэй хэсгийг сүүлд нь зурна. Зургийг усан будгаар зурсан зурагтай харьцуулан хараад зурах арга ажиллагааны хувьд өөр ямар ялгаа байгааг тодруулан ярилцаарай (Зураг 66).



Зураг 67. Хүнс, эд зүйлсийн өнгө бичлэгийн илэрхийлэл



Дээрх гурван зургаас өөрт таалагдсан нэг зургийг хуулж зураарай. Дараа нь багшийн зааврын дагуу натюрморт зурах дадлагын ажил хийнэ (Зураг 67).



Зураг 68. Станислав Золадзын зурсан усан будгийн зураг



Польшийн зураач Станислав Золадз нь байгалийн зургийг усан будгаар зориуд бодит мэт сэтгэгдэл төрөхүйц зурдаг зураач юм. Түүний зургуудыг усан будгаар зурсан гэхэд итгэмээргүй санагддаг. Тэрээр ихэвчлэн голын эрэг, усны тусгал зурах дуртай. Энэ зориуд гэрэл зураг мэт зурдаг. Усан будгийн арга ажиллагааг төгс эзэмшиж чадвал ямар сайхан зураг зурж болдгийг түүний бүтээлээс харж болно.



Гурван өнгийн уусалтыг усан будгаар хийж туршаарай.




Зураг 69. Усан будгаар олон өнгийн уусалт гаргах дасгал

ХҮНИЙ БИЕЙН ЕРӨНХИЙ ХАРЬЦААГ ЗӨВ ЗУРЖ ДҮРСЛЭХ



Эртний Грек, Ромын үеэс эхлэн хүний биеийн гоо сайхныг дүрслэх урлагийн бүтээлүүдэд тусгаж иржээ. Дүрслэх урлагийн бүтээлийг ойлгох, зурж дүрсэлж сурахын тулд хүний биеийн ерөнхий харьцааны талаар зохих мэдлэгтэй болно. Аливаа юмсын жижиг хэсгүүдийг ерөнхий том хэмжээнд нь, нэг юмыг нөгөөтэй нь жишиж үзэхийг харьцаа гэдэг. Хүний биеийн харьцааг илэрхийлэхдээ толгойн өндрийн хэмжээг харьцааны нэгж болгон авч үздэг. Хүн бүрийн биеийн өндөр, намаас шалтгаалж харьцаа нь өөр өөр байна. Дунджаар насанд хүрсэн хүний толгойн өндөр нь биеийн өндөрт толгойн хэмжээнээс гадна 7 дахин багтана. Биеийн өндрийн дундаж нь аарцаг дээр буюу хажуу талаас ташаан толгой дээр байна. Доош унжуулсан гарын хурууны үзүүр нь дунд чөмөгний дунд хэсэгт тохирч байна. Нярай хүүхдийн толгойн өндөр биедээ 4 дахин орчим, 6 настай хүүхдийнх биеийн уртад 5-6 дахин багтана. Хүний биеийн харьцаа, хөдөлгөөнийг зурахдаа цөөн зураасаар хурдан зурахыг хичээж, хамгийн чухал нь байнгын дасгал сургуулилалт хийж, хэвшүүлж чадвал зурах чадвар эзэмшинэ (Зураг 70).




Зураг 70. Хүүхэд болон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүний биеийн харьцаа



Ангидаа бие биенээ хэмжих, зурах, хүний биеийн ерөнхий харьцааг оновчтой зурсан зураачдын бүтээлийг судлах, ажиглах зэргээр суралцаарай. Бие, биеийнхээ өндрийг хэмжиж, нэгж буюу толгойн өндөр биедээ хэд дахин багтаж байгааг шугамаар хэмжих, харандаагаар зайнаас

баримжаагаар хэмжих зэргээр дасгал ажиллана. Биеэс хэмжээ авахдаа толгой дээрээ ном тавиад нүүрэн талаас эрүү хүртэл хэмжээд, тэр хэмжээ нь биед хэд дахин багтаж байгааг тоолно.

Хүний биеийн ерөнхий харьцааг зурах явцад та бүхний хэмжээ, харьцааны тухай мэдлэг хөгжинө.



Зураг 71. Леонорда да Винчи. Хүний биеийн харьцааг харуулсан зураг. 1490. Итали, Венец



Зураг 72. Микеланджело Буонаротти. “Давид” 1501-1504. Итали, Флоренц




Хүний биеийн ерөнхий харьцааг баримжаалан зурж сурахын тулд таталбар зурах дасгал олон удаа хийж хөдөлгөөн, онцлог төрх, донжийг сайтар бодож зурах хэрэгтэй.

Зураач Леонорда да Винчи хүний биеийн харьцаа шоо дөрвөлжин болон тойрогт багтдагийг баталж, дүрслэн харуулжээ (Зураг 71).

Сэргэн мандалтын үеийн зураач, барималч Микеланджелогийн “Давид” бүтээлийг эр хүний бие бялдын төгс харьцааг харуулсан бүтээл гэж үздэг. Бүтээл дэх харьцааг гар, толгой нь биедээ хэд багтаж байгаа зэргийг ажиглаж хэмжээрэй. “Давид” уран баримал яагаад хүний төгс бие бялдар, гоо сайхныг харуулсан бүтээл болохыг ярилцаж, сэтгэгдлээ солилцоорой (Зураг 72).

Дүрс, зураас ашиглан зурсан хүмүүсийн хөдөлгөөнийг ажиглаж, суралцана уу.



Зураг 73. Хүний биеийн харьцааг тооцон байгуулалтын зураг зурсан байдал



Гэр бүлийн гишүүдээс дээрх аргаар, харьцаа, төрхийг нь тооцон зурж үзээрэй. Хүний биеийн өндөр, өргөнд толгой хэд дахин багтдагийг зургаас ажиглана уу. Хүний босоо, суугаа байдалд биеийн өндөрт толгой хэрхэн харьцаж байна вэ?

Дүрслэх урлагийн бусад сурах бичиг дэх хүний зураг дүрслэл, хүний биеийн хөдөлгөөнийг зурах сэдвүүдийг дэлгэрүүлэн судлаарай.



Зураг 74. Хүнийг бодит байдлаас харж зурахдаа биеийн үндсэн харьцааг тооцон байгуулалт хийсэн байдал



Сурагчид өөрийн болон бусдын бүтээлд ажиглалт хийж, харьцааг зөв тусгасан эсэхийг шалган ярилцаарай.

ХҮНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ИЛЭРХИЙЛСЭН ТАТАЛБАР, СУДАЛБАР ХИЙХ



Таталбар хийж, өөрийн бодол санаагаа дүрслэлээр чөлөөтэй илэрхийлэх аргад сурах, таталбар байнга хийснээр тогтоолтоо сайжруулан, бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх аргад суралцах талаар ярилцана.



Зураг 75. Таталбар зургууд



Таталбар зураг нь богино хугацаанд тухайн зүйлийн дүр төрх, утга агуулгыг илэрхийлэн хурдан дүрсэлсэн уран зураглал юм. Таталбар буюу «Наброска» зургийг ерөнхийд нь түргэн зураг гэж нэрлэдэг. Таталбар зургийн мөн чанар нь сурагч тухайн зүйлийн дүр, донж байдлыг хурдан тэмдэглэн авч боловсруулан уран бүтээлдээ бодит амьдралын үнэн төрх, гоо сайхныг харуулахад үнэ цэнтэй зургийн тэмдэглэл болдог.



Таталбар зурах нь зурах зүйлийн ерөнхий шинж онцлогийг хоромхон хугацаанд оновчтой цөөн зураасаар дүрслэх аргыг судална. Таталбар зурагт дүрслэлийг ерөнхийлөн зурдаг. Юмсын бүх шинжийг тоочилгүй хамгийн гол онцлогийг дүрсэлдэг. Хурдан бөгөөд ерөнхий гэсэн зарчмаар таталбар зураг зурдаг учраас сурагчид зурж буй зүйлийнхээ гол чухал хэсгүүдийг олж, зурж сурахад тусалдаг төдийгүй,



Зураг 76. В.А. Серов “Балетчин Т.П.Карсавинагийн хөрөг”. 1909

нүдний ур, гарын ур, ухааны урыг хөгжүүлэх нөхцөл болдог. Таталбар нь бүх төрлийн зураг зурах үндсэн суурь болно.

Таталбар зурахдаа зохиомжийг зөв оновчтой шийдэх асуудлууд орно. Таталбартаа хүний гадаад хэлбэр дүрсийг сайн ажиглан, биеийн галбир бүтэц, ааш зан бусдаас ялгарах хэв шинжийг ойлгон дүрслэх нь чухал.

Хөдөлгөөн харуулсан судалбар хийхэд эхлээд таталбар зураг хийнэ, Таталбар зураг нь хүн амьтны загвар дүр төрх, гол утга санааг илэрхийлж хурдан, товчхон дүрсэлсэн уран зураглал юм. Тухайн зурж буй хүн нь удаан хугацаанд хөдөлгөөнгүй байж чадахгүй учраас зургийг маш богинохон хугацаанд зурдаг.

Хүний хөдөлгөөний зургийг хурдан бөгөөд ерөнхий гэсэн зарчмаар таталбар зураг зурагддаг учраас сурагчдад зурж буй зүйлийнхээ гол чухал хэсгүүдийг олж, зурж сурахад тусалдаг. Судалбар нь юмсын хамгийн гол онцлогийг зураасаар зурсан зурган тэмдэглэл юм (Зураг 77).

Байгуулалтын зураасыг биеийн үндсэн дүрсийн зураасанд саад болохгүй бүдэг зурж тэмдэглэнэ.



Зураг 77. И.Е.Репин. “Элеонора Дузе”. 1891. Судалбар.



Судалбар зураг нь аливаа уран бүтээл хийхийн тулд гол ба туслах дүрүүд болон уран бүтээлд орох дүр, дүрслэлүүдийг судалж зурсныг хэлнэ. Сурагчид юмс, үзэгдэл, амьдрал, байгалийн мөн чанарыг танин мэдэх, зурах үр чадвараа сайжруулахын тулд судалбар зураг байнга хийнэ. Уран бүтээлийн эх дүрүүдийн дагуу зохиомж байрлалыг сонгон боловсруулахын тулд эрэл хайлт хийж тодорхой, байгаль, юмс, үзэгдлийг судалж зурна.



Зураг 78. И.Е.Репин “Л.Н.Толстой бичгийн ширээнийхээ ард” 1891 он.



Өөрийн гэр бүлийнхэн, найз нөхөд, орчинд байгаа хүмүүсийнхээ сууж, хэвтэж, зогсож, тоглож байгаа зэрэг үйл хөдлөлийг ажиглан харж зурахад тохиромжтой мөчийн зургийг аваарай.

Авсан зургийнхаа талаар бусадтай ярилцаж нэг зургийг сонгон тухайн зургаа таталбар, судалбар зургийн аргаар зурж, зурсан арга ажиллагааныхаа талаар ярилцаарай.

“АНТИКВА” ҮСГИЙН УРАН БИЧЛЭГИЙН ОНЦЛОГ



Уран бичлэг нь дүрслэх урлагийн зураасан зургийн нэг төрөл бөгөөд анх бичиг үсэг үүсэх болсон цаг үеээс өнөөг хүртэл олон арван төрөл зүйл болон хөгжсөөр иржээ. Эдгээр төрлүүдийн нэг нь бидний бичиг үсгийн өнөөгийн хэрэглээнд түгээмэл ашиглагддаг “Антиква” шрифт юм. “Антиква” гэдэг нь Латин хэлний “antīqua” буюу “эртний” гэсэн утгатай үг юм. Энэхүү уран бичлэгийн нэг төрөл нь Европын сэргэн мандалтын үед үүссэн бөгөөд XVII зууны үед арай өөр хэлбэрт шилжиж XX зуунаас орчин үеийн хэв маягтай болон шинэчлэгдсээр иржээ. Компьютер дээр байдаг “Times new Roman” шрифт нь Антиква уран бичлэгийн хэв шинжийг илтгэдэг.

Antiqua


Зураг 79. Сэргэн мандалтын үеийн “Антиква” уран бичлэг

АНТИКВА

Зураг 80 Орчин үеийн “Антиква” уран бичлэг



Антиква уран бичлэгийн үсэг бүр тодорхой байгуулалт, хэмжээ, харьцаатай байдаг. Өргөн, нарийн хоёр төрлийн зураас болон үсгийн дээд, доод талд тойргийн байгуулалтыг ашиглагдаараа энэ уран бичлэгийн төрөл бусад шрифтээс ялгардаг. Уран бичлэгийн энэ төрөл нь хуучны, үнэ цэнэтэй, гоёмсог, чамин мэдрэмжийг илтгэдэг онцлогтой (Зураг 79, 80).



Зураг 81. “Антиква” уран бичлэгийн А үсгийн байгуулалт



Ам дөрвөлжин шугам татаж “А” үсгийг дуурайн зураарай. Өөрийн нэрийг “Антиква” үсгийн уран бичлэгээр бичээрэй.

Антиква уран бичлэгийг шрифтийн зориулалтын үзгээр бэхэнд дүрж бичдэг уламжлалтай байсан. Компьютерын хэрэглээний программууд болон төрөл бүрийн хэвлэх төхөөрөмжүүд хэрэглээнд нэвтэрснээр орчин үед уран бичлэгийг гараар бичих хэрэгцээ багассан байна.

Антиква уран бичлэгийг зориулалтын олон төрлийн хушуутай үзгийг бэхэнд дүрж бичдэг. Эдгээр хушуу нь ихэвчлэн дөрвөлжин хэлбэртэй байх ба нарийн зураасыг нэг эгнээгээр, өргөн зураасыг хоёр эгнээгээр зурж бичдэг.

Уран бичлэгийн энэ төрөл нь зураачаас нягт нямбай байдал, уран сэтгэмж, нарийн мэдрэмж шаарддаг онцлогтой.



Зураг 82. “Антиква” уран бичлэгийн үсгийн байгуулалт



Зураг 83. Шрифтийн үзгийн сольдог хушуунууд



Зураг 84. Шрифтийн үзгээр бичих байдал




Антиква уран бичлэгийн төрлөөр бичсэн хаяг, реклам, урилга, танилцуулга гэх мэт зүйлсийг олж тэдгээрийн онцлог ялгааны тухай ярилцаарай.

БАР ЗУРГИЙН АРГА АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАЖ БҮТЭЭЛ ХИЙХ



Бар зургийн дүрслэлийн бүтээлийн онцлог, арга ажиллагааг ажиглаарай.



Зураг 85. С.Жамц “Атар”
45x32 см. Хулдаасан бар



Зураг 86. Кацусика Хокусай. “Канагавагийн хүчит
давлагаа” /”Фужи уулын 36 төрх” цуврал төмөр бар./
Өнгөт бар зураг, 25.7 x 37.8 см. 1829-1833 он.



Зураг 87. Японы сурагчдын урласан хулдаасан бар зургууд



Бар зураг (франц хэлний: Gravure хэмээх үгээс гаралтай) оросоор “Гравюра” гэх бөгөөд эртний түүхтэй, зураасан зургийн нэг төрөл юм. Дорно дахинд бар зургийн урлагийг “Дардас” гэж нэрлэж байв. Бар зураг анх Хятад улсад үүссэн гэж үздэг. Модон бар (hulon – мод, grapho – бичих, зурах үгийн утгатай) -ыг Монголчууд нэн эртнээс бичиг, хэвлэлд өргөн хэрэглэж ирсэн түүхтэй. Тухайлбал Монголын Кидан аймгаас эхлэн бусад аймагт X-XIII зуунд модон бараар ном хэвлэдэг байсныг Ц.Шүгэр “Монгол модон бар” номондоо бичсэн байдаг. XV-XVI зууны үеэс Европ тивд модон бар хүчтэй хөгжиж байсан гэдэг. XVII-XVIII зуунд Япон улсад өнгөт модон бар зураг хөгжиж байжээ. Бар зургийг мод, хулдаас, чулуу, төмөр, зэс дээр ухах, хонхойлох, сийлэх аргаар хэв

хийж, цаасан дээр барлан дардас гарган олшруулдаг онцлогтой. Барыг офорт, акватинт, хуурай зүү зэрэг олон өвөрмөц хэлбэрээр хийнэ. Бүх төрлийн барыг бүтээхэд гурван үндсэн арга байна. Мод, хулдаасанд (ингэмэл) дүрс сийлж, цаасан дээр хэвлэх нь өндөр хэвлэлийн аргад ордог. Ихэнхдээ нимгэн төмөр дэвсгэрт дээр химийн аргаар хороор идүүлж, бар зураг хийхийг гүн хэвлэлийн арга гэнэ. Гол төлөв офорт хуурай зүүгээр хийнэ. Өргөн (хавтгай) хэвлэлийн аргад чулуун бар ордог. Бар зурагт сийлбэрийн хутга хэрэглэнэ. Мөн битүү буюу тойрог үүсгэх зураас ухдаг “Ухам” гэх багаж, өнцөг үүсгэсэн зураасыг сийлдэг. “Жишүү” гэх нэртэй зөвхөн нэг талдаа иртэй багажуудаар сийлнэ. Сийлэхдээ ямагт биеэс гадагш түлхэж сийлдэг. Барын зураг ихэнхдээ хар цагаан өнгийн хослолоор ялгагдана.




Бар зургийн төрөл болон аргыг судалж болно. Үүнд:

1. Өндөр хэвлэлийн аргад мод, хулдаасан дээр сийлэх
2. Өргөн хэвлэлийн аргад чулуун барын ажиллагаа
3. Гүн хэвлэлийн аргад төмөр барын ажиллагаа тус тус ордог.



Зураг 88. Бар сийлэх багажууд болон зөв барилтын зураг



Зураг 89. Бар зургийн хулдаас, мод сийлэх ухмыг хэрхэн барьж ямар зураас гаргахыг үзүүлсэн зургууд



Бар зураг урлах дараалал, арга:


- Өөрийн сонгож төлөвлөсөн зүйлээ зурж бэлэн болгоно.
- Дараа нь гэрэлтүүлэгч, хавтгай шил болон хортой цаас ашиглан зурсан зургаа буруу харуулан дахин зурна.
- Хээгүй, зөөлөн, (олсон артай) цагаан хулдаас хэсэглэн авч, өнгөн талыг зүлгүүрдээд, тослог зүйлээр арчин зөөлрүүлж болно.
- Хулдаасан дээр зургаа буруу харуулж зурсан талаас нь дахин зурж буулгана. (Зураг дардас дээр зөв болж буудаг.)
- Хулдаасанд буулгасан зургаа тосон балаар тодруулж болно.
- Зургийн дагуу үл хэвлэгдэх хэсгүүдийг ухагч багажаар (ухам) хонхойлон сийлж эх бэлэн болгоно.
- Хэвлэгдэхгүй томхон талбайг гүн ухдаг. Зурж буй зүйлээ байнга толинд харж, зөв эсэхийг шалгаж байгаарай. Шулуун зураасыг шугам тавьж дагуулан ухаж болно. Ухагч багажийн үзүүрийг ямагт өөрийн биеэс гадагш чиглэлд түлхэж ухах нь ашигтай байдаг.
- Хэвлэлийн тосон будгийг хатуу хавтгай зүйл дээр асгаад булаар жигд тараана. Будагтай булыг сонин дээгүүр өнхрүүлж будгийг багасгана.
- Сонин дээрээс булаа авч шууд сийлсэн эх дээгүүр өнхрүүлэн будах хэрэгтэй.
- Дардас буулгах цаасаа будсан эх дээрээ тохируулан тавьж хөдөлгөөнгүй дараад, ган халбага болон бөөрөнхий зүйлээр төвөөс тал тал тийш нь жигд даран сайн наалдуулна. Дардсаа хулдааснаас эгц дээш татан хуулж авна.
- Хэвлэгдэн гарсан зургийг дардас гэдэг.



Зураг 90. Хулдаасан бар хийхээр төлөвлөсөн зураг



Зураг 91. Хулдаасан дээр буулгах зургаа буруу харуулан зурсан зураг



Зураг 92. Хулдаасан бар дардаслах арга



Зураг 93. Хэвлэсэн дардас

Өнгөт бар зураг хийх аргаас:



Зураг 94. Өнгөт бар зураг

Өнгөөр гаргах зураг бүрийг тус тусад нь сийлж, өнгө нэг бүрээр дардаслана. Дараах жишээг ашиглаарай.



Зураг 95. Өнгөт бар зураг хийх дараалал

Хулдаасан бар зургийг хэдэн ч өнгөтэй гаргаж болно. Өнгө зөрүүлэхгүй дардас авахын тулд хамгийн хөнгөн өнгийг эхлэн дарна. Дараа нь дунд зэргийн өнгийг сүүлд нь хүнд өнгийг дарах дарааллаар ажилладаг журамтай.



Багууд бүтээлээ тайлбарлан туршлага солилцоно.

УРЛАГИЙН БҮТЭЭЛЭЭС ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ ЗУРЖ ИЛЭРХИЙЛЭХ



Дэлхийн болон Монголын нэртэй хөгжмийн зохиолчдын бүтээлүүдээс сонсоорой. Н.Жанцанноров “Цагаан суварга”, Б.Дамдинсүрэн “Хэнтийн өндөр ууланд”, Б.Шарав “Сэрсэн тал”, П.И.Чайковскийн “Хунт нуур” бүжгэн жүжгийн хөгжмөөс сонсон ярилцах.



Уран зураг бол харах яруу найраг, яруу найраг бол сонсох уран зураг гэж эртний суутнууд хэлсэн байдаг. Уран зураг, яруу найраг, хөгжим нь бүгд өөр өөрийн хэлээр хүний мэдрэхүйд гоо сайхныг хүргэн магтан дуулдаг. Монголын нэрт уран бүтээлчид байгалийн гоо сайхны тухай олон сайхан бүтээл туурвижээ. Ардын зураач Н.Цүлтэмийн “Хурмастын чуулга” бүтээлд тал нутаг, байгалийн гоо сайхан, үүлний хөдөлгөөн, хувирал хэрхэн туссаныг ярилцах. Ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэнгийн “Зугаацахаар мордсон нь” найраглалын Үүл хэсэгт:

*... Арслан барс хоёр ноцолдож байгаа ч юм шиг
Ачаатай цагаан тэмээ хэвтэж байгаа ч юм шиг
Араг үүрсэн эхнэр бүжиглэж байгаа ч юм шиг
Хувилгаан цагаан үүл хурмастын цагаан үүл ...*

... гэж гайхалтай урнаар үүлний агшин зуурын хувирах хөдөлгөөнийг сэтгэлд буутал дүрсэлснийг ярилцах.



Зураг 96. Н.Цүлтэм. Хурмастын чуулган, 1977. Зотон, тос

Монголд төрсөн авьяаслаг зураач охин Н.Рушева (1952-1969) бүжгэн жүжгээс төрсөн сэтгэгдлээс дараах уран таталбаруудыг зуржээ.



Зураг 97. Н.Рушева. Таталбарууд (1952-1969)

Төрийн шагналт хөгжмийн зохиолч Ц.Чинзоригийн “Зүүдний говь” дууг сонсож, дууны зохиомж, ая эгшиг, хэмнэл, давтамж нь ямар уран зураг, дүрслэлийг санагдуулж байгааг ярилцаарай. Зураач Ц.Энхжингийн “Говь” уран зураг Зүүдний говь дууны ая эгшиг, хэмнэлтэй адил байна уу?




Зураг 98. Ш.Жадамба. Дарвийн үзэмж. 30x40 см. Зотон, тос



Хөгжмийн бүтээлүүдээс сонсож, уран зохиол, яруу найргийн бүтээлүүдтэй танилцаж хэмнэл, давтамж, өнгө аяс, утга санааны тухай ярилцан үзэл бодлоо солилцож, төрсөн сэтгэгдлээс үүдэн дүрслэн илэрхийлээрэй.

Алдарт зураач П.Пикассогийн “Сууж буй эмэгтэй” (1937) бүтээлд хүний нүүр, бодит дүр төрхийг өөрчилж өвөрмөц сэтгэн зуржээ. Та бүхэн хүн, амьтан, эдлэл юмсын бодит байдлыг хувирган өөрчилж зурж үзээрэй. Бодит байдлыг хувиргах, өөрчлөх бүтээлч ажил нь шинээр чөлөөтэй сэтгэх, аливааг өөр өнцгөөс харах, зохион бүтээх сэтгэлгээг төлөвшүүлэхэд тустай.



Зураг 99. П.Пикассо “Сууж буй эмэгтэй” 1937



Дүрслэх урлаг, яруу найраг, уран зохиол, хөгжим, бүжиг, жүжиг зэрэг урлагийн төрлүүд нь хэлбэрийн хувьд өөр боловч өнгө, зохиомж, хэмнэл, давтамж, утга санаа зэрэг дүрслэлийн ижил хэлтэй юм. Урлагийн бусад төрлүүд дэх тэдгээр дүрслэлийн хэлийг ажиглаж, төрсөн сэтгэгдлээ зурж дүрслэн илэрхийлээрэй.

Дэлхийн болоод Монголын нэртэй зохиолч, хөгжмийн зохиолчдын бүтээлтэй танилцаж, төрсөн сэтгэгдлээ зурагт дүрсэлж, гэрийнхэнтэйгээ ярилцаж, сэтгэгдлийг нь сонсоорой.

Сэтгэгдлээ илэрхийлэн зурах

Байгалийн гоо сайхныг танин мэдүүлж, эх орноо хайрлах, өвлөн үлдээх. Жишээ нь : “Зусланд”, “Зуны өглөө”, “Хаврын анхны бороо” гэх мэт сэдвүүд нь эх нутгаа хайрлах сэтгэл төрүүлэхээр байна.



Юмыг сэдэвлэн зурах нь сурагчдад бие даасан уран бүтээл хийх эхлэл нь болдог.

Сэдэвт зургаар сурагчид орчны юмс, үзэгдэл, амьдрал, байгалийг ажиглах, юмыг оюун ухаандаа дүрслэн бодож зурдаг. Урьд нь зурсан, үзсэн зургаа сэргээн бодох зэрэг сэтгэл зүйн ажиллагаанд тулгуурлан сэдэвт зураг зурах судалгаа хийнэ.



Хүүхдийн бүтээл нь юуны өмнө сэдвээ оновчтой сонгох, эрэл хайгуул хийх, урьдчилан олон хувилбар эскиз гаргах, хамгийн оновчтой зохиомжийг сонгон эх зургаа буулгах, бүтээлээ туурвих, ярилцах, үнэлж цэгнэх гэсэн тодорхой үе шат дамждаг.

1. Сэдэв сонгох (Амьдралаас гярхай ажиглалт эрэл хайгуул хийх, давтагдмал биш шинэ утга санаагаар зурах)
2. Эскиз хийх (Зурах зургаа урьдчилан төсөөллөөр сэтгэлдээ зурах, олон хувилбараар эскизээ хийх, таталбар, судалбар хийх /хар, өнгөт/)
3. Эх зургаа зурах (Зурах дэвсгэртийн байрлалаа зөв сонгох /хэвтээ, босоо/)



- Бүтээлийн агуулга, утга санаа, шийдлийг өөрт төрсөн сэтгэгдлээрээ илэрхийлэх.
- Хүн, амьтан ба юмсын цаана наана байгаа буюу зэрэгцэн байгаа байдал нь өөр хоорондоо болон, юмс тус бүрийн харьцааг зөв гаргаж чадсанаар харагдах байдал ойлгомжтой болно.
- Байгалийн өнгө, гэрэл, алслалт, зурж буй зүйл тус бүрийн онцгой шинжийг гаргаж чадсан тохиолдолд бодит байдалд ойр харагдана.
- Хэд хэдэн юмыг хамтатган зурахдаа тус бүрийн хэсгүүдийн харьцаа төдийгүй юмсыг өөр хооронд нь харьцуулах нь чухал байдаг.



Сэдвүүдээс санаа авч өөрөө зохиож зураарай.

Үүнд:

1. Хүслийн орчин, Миний хот, Би хэрвээ хотын дарга бол, Хүүхдийн хот,
2. Сайн найз, Надаар хийлгээч, Тусч хүү,
3. Аялгуу, Хурд, Хүслийн гэгээ.

МОНГОЛ ЗУРГИЙН ДҮР, ДҮРСЛЭЛИЙН ОНЦЛОГ



Дараах зургийн зохиомж, өнгө, дүр дүрслэлийн онцлогийг ажиглаарай (Зураг 99).



Зураг 100. М.Уранбэрх. “Үлэмжийн чанар”. 70x170 см



Монгол зураг нь задгай дэлгэр зохиомжтой, уянга яруу, цэвэр хурц тод өнгө зонхилсон чөлөөт сэтгэлгээ, уран сайхны хэтрүүлгээр баялаг өвөрмөц онцлогтой бүтээл байдаг. Монголчууд харсан үзсэн бүхнээ тоочин зурдаггүй, амьдралын нийтлэг хэв шинжит дүрийг сонгон зурна. Монгол зурагт амьдралын үнэнийг уран сайхны аргаар гол дүрд шингээн том, тодоор авч туслах дүрүүдийг түүнд зохицуулан жижгээр зурах аргатай. Задгай зохиомжийн зурагт гол дүрийг товойлгон үзүүлэхийг чухалчилдаггүй. Бүх дүрийг жигд тэгш эрхтэй зурдаг онцлогтой. Монгол зургийг уран сайхны дүрслэлийн аргаар нь нэгдүгээрт, амьдралын бодит байдлаар энгийн дүрслэх хоёрдугаарт, хээлж угалзлан дүрслэх гэж хувааж болно.

Манай ард түмэн хээ угалзыг бэлгэдэл болгон их дүрсэлдэг. Хээлж угалзалсан дүрсийг тайлж уншихдаа чадамгай билээ. Монгол зурагт усыг амьдралтай, модыг мөнхийн хөдөлгөөнтэй адилтгана гэх зэргээр уул, үүл, ус, мод, цэцэг навч зурдаг. Энэ нь байгалийн дүрслэл биш цаанаа ямар нэг утга санаа агуулсан байдлаар дүрсэлж ирсэн түүхтэй. Үлгэр домгийг болон бурхан шүтээнийг зурахдаа байгалийг хээлж угалзлан уран сайхны аргаар дүрсэлдэг заншилтай.

Монгол зургийн хөгжилд шүтээн зургийн урлаг чухал нөлөөтэй байв. Шүтээн зургийг дүрслэх харьцаа хэмжээ, биеийн хөдөлгөөн, суудал, царай зүс, өнгө будаг зэрэг нь бурханы номын тодорхой утга санаа, гүн ухааны чиглэлээр тиглэгдэн зурагддаг.

Тухайлбал, нэрт зураач өндөр гэгээн Гомбодоржийн Занабазар (1635-1723) судрын ёсонд заасан тиг, хэмжээ, горим журмыг баримтлахдаа монгол ахуйгаас сэтгэн бясалгаж, монгол хүний шинж, биеийн гоо сайхныг бүтээлдээ шингээн туурвиж байжээ. Г.Занабазарын “Ногоон Дара эх” бол монгол эмэгтэйн гоо жавхланг илтгэсэн уран сайхны хэв шинжит дүрийн бүтээл юм.

Монгол зургийн зохиомж

Монгол зургийн гол дүрийг томоор дүрсэлж, харааны цэгийг төвлөрүүлэн тэгш хэмийн зохиомж бүхий дүрслэлтэй зурдаг. Хоёрдугаарт, их өндөрлөгөөс харсан мэт харааны олон цэгийн байгууламжтай, үйл явдлыг хүүрнэн өгүүлэх хэлбэрээр илэрхийлсэн задгай зохиомжтой байна.

Сэдэвт зурагт юмс, үзэгдлийг дүрслэхдээ хавтгайд тараан байрлуулж, орон зайн өвөрмөц өгүүлэмжээр илэрхийлэн зурдаг. Монгол зурагт орон зай илэрхийлэхдээ бийрийн даралт таталтаар үүсэх зураасны өргөн нарийн хэлбэр, өнгийн дагнаасын алгуур уусалт, шилжилт зэрэг уран сэтгэлгээний аргууд ашиглана. Шувууны нислэгийн өндрөөс харж буй мэт сэтгэж, харааны түвшний шугамыг дээгүүр авч зурдаг. Эд зүйлс, үйл явцыг дүрслэхдээ дан давхар өнгийн дагнаас, зураасны хэмнэл хөдөлгөөнөөр орон зай илэрхийлдэг. Энэ нь сэдэвт зургийн уран сайхны өвөрмөц чанар юм. Монгол зурагт уудам их газар орчинд болж байгаа олон үйл явдлыг нэг хавтгайд, задгай зохиомжийн харааны олон цэгтэй, дүрсүүдийг хийсвэрлэл, төсөөллөөр хоорондоо уялдаа холбоо, шүтэлцээтэй байрлуулан зурдаг онцлогтой.



Зураг 101. Б.Сэнгэцохио “Уургач”.

Монгол зургийн өнгө зохицол

Манай зураач нар шүтээн болон уран зураг, чимэглэлийн бүтээл хийхдээ өнгийн бэлгэдлийг өргөн ашигладаг. Шүтээн зураг зурахад цагаан, шар, улаан, ногоон, хөх гэсэн үндсэн таван өнгийг голлон хэрэглэдэг. Энэ үндсэн таван өнгөөс суурь 32 өнгө найруулж гаргаад түүнийгээ 108 өнгө хүртэл хувирган өөрчилдөг төдийгүй мянган тоот өнгө хувирган гаргах увдис бий гэж үздэг. Монгол зурагт мөн энэ таван өнгийг ихээхэн хэрэглэсэн байдаг. Монгол зурагт өнгөөр ажиллах бас нэг өвөрмөц онцлог бий. Энэ нь ертөнцийн нар ямагт дээрээс гэрэлтдэг. Нарны гэрэл тэнгэрээс газрын хөрсөнд тусах замдаа бүхнийг гийгүүлнэ. Иймээс үүл, уул, ус, ургамал, амьтан зурахдаа нар тусч байгаа бүхнийг хөнгөн өнгөөр зурж газрын хөрс хүртэлх сүүдэр буух хэсэг бүрийг хүндрүүлсэн өнгөөр зурдаг байжээ. Манай уран

VIII АНГИ

зураач нар, тэнгэр газрын өнгийн зохицлыг чадамгай олж заншсан учир Монгол зураг ихээхэн гэрэл гэгээтэй, яруу уянгалаг байдаг.

Өнгийг хөнгөнөөс хүнд рүү аажмаар шилжүүлэх эрэмбэ дараалал нь өнгийн дагнаас бий болгоно. Монгол зурагт өнгийн дагнаас нь үүл, уул, ус, мод, цэцэг, навч зэрэг дүрслэгдэж буй зүйлсийн хэлбэр, дүрс, бүтцийг орон зайн эзлэхүүнтэй болгож харагдуулдаг.

Өнгийг хөнгөнөөс хүнд рүү, хүндээс хөнгөн рүү дагнааслах олон арга бий. Монгол зурагт дагнаасыг хэрэглэхээс гадна хэсэг газар сүүдэртүүлэн хэлбэржүүлэх, өнгө дагнаасын харьцаа, ханалт ашиглан хэлбэр, орон зайг илэрхийлэх олон арга хэрэглэдэг билээ.

Манай зураачдын уран бүтээлд:

Нэгдүгээрт, хүнд өнгөөс хөнгөн рүү өөрөөр хэлбэл товгор хэсэгт хүнд өнгө тавьж аажмаар хөнгөрүүлэн гэрэлтэй болгон дүрсэлсэн бүтээлүүд нэлээд байна (126 дугаар зураг А).

Хоёрдугаарт, товгор хэсэгт хөнгөн өнгө тавьж, сүүдэртэй хэсэг рүү хүндрүүлэн шилжүүлж, гэрэл сүүдрийн ялгамж ашиглан зурсан бүтээл олон байдаг (126 дугаар зураг Б).



а.



б.

Зураг 102. Орон зай илэрхийлэн зурах хоёр арга

Судлаач Л.Сономцэрэн бичихдээ: “Манай зураачдын бүтээлийг үзэхэд голдуу хүнд өнгөөс хөнгөн рүү, өөрөөр хэлбэл, товгор газар хүнд өнгө тавьж зурж ирсэн бол Б.Шарав түүний эсрэг товгор газар нь хөнгөн өнгө тавьж байжээ. Тэр арга нь өнгийг хөнгөнөөс хүнд рүү, гэрлээс сүүдэр рүү шилжүүлэн, хүнд хөнгөн өнгө, гэрэл сүүдрийн зохиороог шинэ маягаар хөгжүүлэхийн эхлэл болжээ” [Л.Сономцэрэн 1987 20.42] гэж тодорхойлсон байдаг. Монголын зураачид алт, мөнгө, оюу, сувд, номин, шүр, тана, зэс, ган гэсэн есөн эрдэнээс олон сайхан өнгө гарган ашиглана. Мөн “Хоргол алт”, “Сааз алт” болон жинхэнэ шижир алтыг нухаж найруулан уран бүтээлдээ өргөн хэрэглэдэг. Монголчууд шунх (улаан), хонд (улбар шар), шар, ногоон, тэн (номин хөх), арам (цэнхэр), энгэсэг (ягаан) гэсэн солонгын долоон өнгийг эцэг өнгө гэж нэрлэдгийг эрдэмтэн Сүмба Ешэйбалжор “Лагшин, зарлиг, тааллын шүтээний шугамын үндсэн хадмал тайлбар цэцгийн үзэсгэлэнт эрхи” сударт дурджээ. Цагааныг будаг бүхэнтэй хольж, олон өнгө гаргадаг байдлаар нь будгийн эх гэдэг. Эх өнгийг будагтай хольж гаргасан ягаан, шаргал, цэнхэр, цайвар ногоон зэрэг өнгүүдийг хүү өнгө гэнэ. Хар цагааныг хольж гаргасан үнсэн саарал өнгүүдийг зарц өнгө гээд чөтгөр, шулам мэтийн муу талын дүр зурахад хэрэглэдэг байв.


Монгол зургийн зураас

Монгол зургийн бүтээлийн үндсэн хэрэгслийн нэг нь зураас юм. Монгол зургийн зураас дүрс, дүрийн хэлбэр, бүтэц, хэмнэл, хөдөлгөөн, донж, алслалт, орон зай

илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. “Монгол зургийн зураас өөрийн дүрслэл, илэрхийллийн аргад тохирсон өвөрмөц хэв маяг, шинж чанар, догшин ширүүн, хатуу, хөшүүн, хөдөлгөөнгүй, уян налархай, уран хөдөлгөөнтэй, хөнгөн зөөлөн, эрч хүчтэй, үлбэгэр сул, болхи бүдүүн, нарийн зэрэг олон шинжийг илэрхийлж, сэтгэл хөдөлгөх удвисыг өөртөө хадгалж байдаг.” [Б.Баяртөр 2 2001] Сэдэвт зураг зурахад зураас нь зургийн хавтгайд тараан байрлуулах дүр, дүрслэлийн давтагдашгүй донж, овор төрх, уран гоё хөдөлгөөн, алслалт, орон зайг маш тод илэрхийлнэ. Орон зай илэрхийлэх зураас нь уян зөөлөн, эхэн ба төгсгөл рүүгээ нарийссан, дундуураа өргөн дөлгөөн хэмнэлтэй байдаг. Монгол зурагт хөдөлгөөн онцгой үүрэгтэй бөгөөд хөдөлгөөний хэмнэлийг чадамгай ашиглана. Хөдөлгөөний хэмнэлээр намба төрхийг, зориг баатарлагийг ч илэрхийлэх нь бий.



Монгол зургийн тигтэй ба тиггүй зурах аргуудыг харьцуулан учир шалтгааныг тайлбарлан ярилцаад, өөрийн сонирхдог амьтныг монгол зургийн аргаар зурж будаарай.



Зураг 103. Бурханч лам Г.Пүрэвбатын шинээр зохион гаргасан мал амьтны тигийн онол. Морь зурах тиг



Зураг 104. Б.Шарав. “Айрагны баяр” зургийн хэсэг.

Монголын шүтээн зурагт тиг хэрэглэдэг бол монгол уран зурагт тиг ашигладаггүй, чөлөөт сэтгэлгээгээр зурдаг онцлогтой.

УРАН ДАРХАН, АРЬСАН БОЛОН ЭСГИЙН УРЛАГТАЙ ТАНИЛЦАХ



Сурагчид өөрсдийн хэрэглэж байгаа эд зүйлс дотор тухайн хичээлтэй холбогдох зүйл байвал, түүнийг юугаар хийсэн болох, хүний хэрэглээнд ямар ач тустай талаар ярилцана.



Хот болон орон нутгийн музей үзэсгэлэн үзэж, уран дархан, арьсан болон эсгийн урлагийн бүтээлүүдийн онцлог, ур хийц, гоо сайхантай танилцах, боловсруулах арга ухаанаас суралцана.

Хүснэгт 5. Уран дархан, арьсан болон эсгийн урлаг

Уран дархны урлал	
Гоёл чимэглэлийн дархны урлал	Хар төмрийн дархны урлал
	

Хүснэгт 6. Эсгийн урлагийн төрөл

Эсгийн урлаг	
Эсгийн урлаг	Ширмэл урлаг
	
Гоёл чимэглэлийн эд зүйлс	Гоёл чимэглэлийн эд зүйлс

Хүснэгт 7. Арьсан урлалын төрөл

Арьс ширэн урлал	
Арьсан урлал	Ширэн урлал
	

Сурагчдыг баг болгон хувааж, уран дархан, арьсан болон эсгийн урлагийн доторх зүйл тус бүрийг харуулсан зурагт тараах материалыг ялган баг тус бүрд өгнө. Жишээлбэл, эсгийн урлагийн бүтээлийг нэг багт, ширмэл урлалын бүтээлийг нэг багт, алт мөнгөн гоёл чимэглэлийн уран дархан нэг багт, хар төмрийн дархныг нэг багт гэх мэтээр өгнө. Багууд өгсөн зургуудыг ажиглаж, өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг эд зүйлс болон бусад урлагийн бүтээлүүдээс ямар зүйлс тус төрөлд хамаарч болохыг цаасан дээр түүж бичнэ. Тус төрөл зүйлийг ямар материалаар хийдэг, түүний бусдаасаа ялгарах онцлог, давуу болон сул талуудыг ярилцаж бичнэ.

Хүснэгт 8. Төмрийн дархны урлал

Хар төмрийн дархны урлал	
Хэрэглэх материал	Хар төмөр, ган төмөр,
Онцлог, давуу тал	Хүний өдөр тутмын амьдралд хэрэглэгддэг, маш бат бөх, хямд,
Сул тал	Амархан өнгө алддаг, ус чийгэнд амархан зэвэрдэг,
Юу хийж болох вэ. . . гэх мэтээр нэмж асуулт бичиж болно.	Цоож, дөрөө, амгай, эргүүлэг, алх гэх мэтээр хэлүүлнэ.



Баг тус бүр өөрсдийн хариуцан авсан төрлийнхөө эд зүйлсийн жагсаалтыг түүврийн аргаар бичсэн байгаа. Тухайн жагсаалтаасаа нэг эдлэл сонгон авч түүнийг хэлбэр хийц, өнгө загвар, хээ чимэглэлийг хэрхэн улам гоё болгож болох талаар багаараа ярилцаж зохиомж хийнэ. Өнгийн цаас, өнгөт эсгий, арьс болон савхин эдлэлийн өөдөс, сур гэх мэт туслах материалуудыг урьдчилан бэлтгэсэн байх бөгөөд багууд түүнийг ашиглаж болно.

МОНГОЛ БИЧГЭЭР ЭВХМЭЛ БОЛОН УРАН БИЧЛЭГ БИЧИХ АРГАД СУРАЛЦАХ



Эвхмэл бичгээр өөрийнхөө овог нэрийг хэрхэн бичихийг ярилцана. Багш өөрөө хэн нэгний нэрний эхний үсгийг зохиомжлон үзүүлнэ.




Монголчууд хөгжлийнхөө түүхэнд олон бичгийн соёлыг эзэмшиж, хэрэглээ болгон хөгжүүлэх явцдаа өөрийн гэсэн “Босоо бичиг”-ээ өнө мөнхөд өвлүүлж ирсэн уламжлалтай билээ. Монгол бичиг нь дэлхийн соёлын салшгүй нэг хэсэг юм.


Уг бичиг нь бусад улс, үндэстний бичгээс эрс ялгаатай, өвөрмөц зохицол, төрхтэйн зэрэгцээ бичих арга барилын хувьд ямар зориулалтаар хэрэглэхээсээ шалтгаалж, хувьсан өөрчлөгддөг, бичлэгийн гайхалтай тиг ёсны тогтолцоотой юм. Жишээ нь: “Эртний тиг”, албан журам, ном ёсны ажлыг гүйцэтгэх “Хичээнгүй тиг”, хурдан түргэн тэмдэглэгээ хийхэд зориулсан “Таталган” болон “Гүйлгэн тиг”, уран гоёмсог, бас нууцлаг дизайны шийдэл бүхий “Эвхмэл тиг” гэх мэтээр олон төрөл буй. Тус бүрийг зургаар үзвэл:




Эртний Монголын түүх судрыг хөшөө чулуунд тэмдэглэж үлдээсэн бичээсүүд, хаадын захидал бичгүүдийг эртний тигээр уян налархай боловч хатуу хошуутай үзгийн зүйлээр уран гоёор бичсэн байдаг. Мөн хулсан үзгээр бичсэн болон сийлж үлдээсэн дурсгалууд ч элбэг.



Хичээнгүй тигээр ацаг шүдийг нь тод гаргацтайгаар бичдэг. Үсгийн зурлага, цэг, тэмдэг зэргийг зөв бичиж сурснаар бусад тигүүдийг сайтар эзэмшиж болдог.



Ацаг шүдийг нэг бүрчлэн зуралгүйгээр ацагны олон цөөн байдалд тохируулан богино, урт нуруу татан гаргаж шүд хэмнэн хялбарчлан түргэн бичсэн бичиг юм. Үүнийг хураангуйлан бичих арга ч гэж хэлдэг. Таталган тигээр хурдан түргэн бичих нь уран бичлэгийн урлаг бөгөөд түүний дээд хэлбэр юм.




“ЭВХМЭЛ ТИГ”-ийг дэлгэрүүлж үзвэл:

XIII зууны үеэс уламжлан ирсэн тамга тэмдгийн зүйлд Юань улсын үеийн дөрвөлжин эвхмэл үсгийн бичих журмаас үзэхэд монгол үсгийн эвхэх горимоор бичсэнтэй ижил үсэг цөөнгүй бий. Монгол эвхмэл үсгийн төрөл зүйлийг босоо, дөрвөлжин, дугуй янз бүрийн хэлбэрээр бичдэг. Ингэж бичсэн үг, үсэг нь уран гоё дүрстэй хээ угалз мэт харагдана. Үүнийг “Эвхмэл үсэг”, “Үсэг эвхэх”, “Хос уянга” гэх мэт олон янзаар нэрлэдэг.

Хүснэгт 9. Эвхмэл тиг

ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ	ᠬ	ᠭ	ᠱ	ᠰ	ᠷ	ᠮ	ᠪ	ᠴ	ᠵ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ	ᠬ	ᠭ	ᠱ	ᠰ	ᠷ	ᠮ	ᠪ	ᠴ	ᠵ
ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ	ᠬ	ᠭ	ᠱ	ᠰ	ᠷ	ᠮ	ᠪ	ᠴ	ᠵ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ	ᠬ	ᠭ	ᠱ	ᠰ	ᠷ	ᠮ	ᠪ	ᠴ	ᠵ
ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ	ᠬ	ᠭ	ᠱ	ᠰ	ᠷ	ᠮ	ᠪ	ᠴ	ᠵ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ	ᠬ	ᠭ	ᠱ	ᠰ	ᠷ	ᠮ	ᠪ	ᠴ	ᠵ
ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ	ᠬ	ᠭ	ᠱ	ᠰ	ᠷ	ᠮ	ᠪ	ᠴ	ᠵ	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ	ᠨ	ᠬ	ᠭ	ᠱ	ᠰ	ᠷ	ᠮ	ᠪ	ᠴ	ᠵ







“Оюун-Эрдэнэ”, “Дэлгэр” гэсэн хүний нэрийг эвхмэлээр бичсэн байдал





Өөрийнхөө нэрийг эвхмэлээр бичнэ үү.

“ХИЧЭЭНГҮЙ ТИГ”-ийг дэлгэрүүлж үзвэл:

Монгол бичгээр сайхан бичиж сурахын тулд үсэг тус бүрийг “Хичээнгүй тиг”-ээр нь судалбал цаашид гарт орж эвлэн тогтдог байна.



Энэ тигүүдийг ашиглан өөрийн нэрийг бичиж будаарай.







Монгол бичгийн талаар Википедиагаас үүссэн үүх түүх, монгол бичгийн хувилбарууд болох Зая Бандида Намхайжамцын зохиосон ойрад аялгуунд тулгуурласан “Тод бичиг”-ийн цагаан толгой, буриад аялгуунд ойртуулж буриад аялгууны онцлогийг тэмдэглэх зорилгоор зохиосон “Вагиндрагийн цагаан толгой”, Манж хэлийг тэмдэглэх зорилгоор 1599 онд Манжийн хаан Нурхачийн зарлигаар зохиогдсон “Манж бичгийн цагаан толгой” (Монгол бичгээс ялгаатай нь үсгийн нуруунд дусал, бинт нэмсэн байдаг) Эвэнк хэлийг тэмдэглэхэд ашигладаг “Эвэнк бичгийн цагаан толгой” (Манж бичгээс санаа авсан байдаг). Монгол бичгийн галиг үсэг болгох зорилготой Аюуш Гүүшийн зохиосон “Али-Гали” цагаан толгой зэргийг судлаарай.



“Монгол” гэдэг үгийг хичээнгүй, таталган тигүүдээр бичиж үзэхийн зэрэгцээ эвхмэл үсгээр ертөнцийн юмсыг бүрдүүлэгч эгэл таван дүрс буюу дугуй, тэгш өнцөгт, гурвалжин, шоо, зууван дүрсэд багтаан бичээрэй. Дараах жишээнүүдээс санаа авна уу.



Ямар дүрстэй төстэй “Монгол” гэсэн бичиг бичигдээгүй байна вэ?

Зураг 105. Эвхмэл бичиг



Бичсэн бичлэгээрээ “Бичил үзэсгэлэн” самбарт байрлуулж сурагчдаар ямар үр дүнтэй болсныг шүүн ярилцуулж, өөрсдөөр нь хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ.



2x21 см хэмжээтэй цаасан дээр өөрийн овог, нэрийг эвхмэл бичгээр бичиж будаад, үсгээ дагуулан хайчлан авчраарай. Ширээн дээрээ наана.

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ЧИГ ХАНДЛАГЫГ ОЙЛГОЖ МЭДЭХ



Дүрслэх урлагийн нэрт төлөөлөгчдийн бүтээлүүд дээр ярилцах



Дүрслэх урлагийн чиг хандлагын талаар дараах мэдээллийг нэрт уран бүтээлчдийн уран зургууд дээр харьцуулах, нэрт төлөөлөгчдөөс нэрлэх зэргээр судална.

Классицизм – сонгодог урлаг

Классицизм нь XVI-XIX зууны Европын урлагийн чиглэл. “Классицизм” гэдэг нэр томъёо латины classisus- тэргүүн зэргийн, үлгэр жишээ гэсэн үгстэй утга дүйнэ. Классицизм, сэргэн мандалтын өв уламжлал дээр тулгуурласан сонгодог чиглэлийг хүлээн зөвшөөрдөг байна. XVII зуунаас Европын улс орнууд антик (Antiguus-эртний) соёлыг сонгодог хэв маягт тооцож, “Классицизм” гэдэг нэр томъёо буй болгосон гэдэг. Классицизм XVII зууны эхэнд Францад үүсэж улмаар Англи, Герман, Итали, Орос улсуудад нэвтэрчээ. Классицизм эрх чөлөө, шударга ёсны төлөө тэмцэгч эрин үеийнхээ бодит баатруудын үйл хэргийг үзүүлэхийг эрмэлзсэнээрээ шинэлэг хэллэгтэй классицизм буюу неоклассицизм болсон байна. Оросын классицизмын гол төлөөлөгч Иван Петрович Мартосын (1754-1835) “Минин Пожарский хоёр” уран баримлаар жишээ авлаа.



Зураг 106. И.П.Мартос. “**Минин Пожарский хоёр**”. 1804-1818 он. Москва. Орос

Москва хотын Улаан талбайд босгосон “Минин Пожарский хоёр” (1804-1818) уран баримал нь хамгийн алдартай билээ. 1611 онд Орос улсад довтолсон Польшийн эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг ардуудыг цэрэглэн босгож, удирдан Москва хотоос түрэмгийлэгчдийг хөөн зайлуулсан Доод Новгородын нутгийн захирагч К.М.Минин, ван Д.М.Пожарский нарт зориулсан хөшөөг Покровын сүмийн дэргэд байрлуулсан байдаг. Минин зүүн гараараа Пожарскийд илдээ өгч, баруун гараараа Улаан талбайн зүгт заан ярьж зогсоно. Түүний царай зоримог, харц нь ширүүн, асар их хүч чадалтай байдал нь эртний баатруудыг санагдуулна. Харин Пожарский баруун гараараа илдний бариулаас атган, зүүн гараараа бамбайгаа түшин сууна.

Классицизмын нэрт төлөөлөгчдөөс: Францын Ж.Л.Давид, Ж.О.Д.Энгр, Ж.А.Гро

Реализм

Реализм нь (realis-биет, бодит) XIX зууны дунд үеэс өөрийн онолтой болсон урлагийн хүчирхэг хэв маяг бүхий чиглэл юм. Биет, бодит юмсыг тун адилхан. төгс илэрхийлэхийг гол зорилгоо болгодог урлаг. Францын уран зураач Г.Курбе:

Уран зураг бол бодитой орших эд юмсыг дүрсэлдэг тодорхой урлаг бөгөөд нүдэнд үзэгддэг юмсаас бүрдэх физик хэллэгтэй гэж үзэж байсан бол Францын зохиолч Э.Золя реалист урлагийн гол шаардлага нь шинжлэх ухааны ололттой холбоотой байх ёстой хэмээн тунхаглаж байжээ. Ф.Энгельс реализмын баатрууд нийтлэг зан чанартай, нийтлэг дүрүүд, нийтлэг орчлонд байрлах тухай хэлсэн байдаг. Нийгмийн амьдралд хөдөлмөрч хүн онцгой үүрэгтэйг реализм онцолдог. Реализмын бүтээлүүдийн ихэнх нь эерэг агуулгатай, хүмүүсийн нинжин сэтгэл, ёс суртахууны дээдлэл, амьдралын үнэ цэн, байгаль ахуй, гоо сайхныг өргөн дэлгэр илэрхийлэхийг чухалчилдаг. Реализм дотроо шүүмжлэлт болон социалист реализм гэх зэрэг нэр томъёогоор хэрэглэгдэж байв. Реализм нь дэлхийн урлагийн олон чиглэл, урсгал салбарлан хөгжих төв нь болсоор иржээ.



Зураг 107. Г.Курбе. “Чулуу бутлагчид” 1849

хоёр хүнд гэрэл, гэгээтэй ирээдүй байхгүй мэт байна. Зураач энд нийгмийн хүнд асуудлыг хөндсөн хэдий ч хүлцэнгүй ажиллах хүмүүсийн өрөвдөлтэй байдлыг үзүүлжээ.

Францын уран зураач Г.Курбе “Реализм бол романтизмын хэсэг юм. Харин миний урлагийн зорилго бол орчин үеэ бодит үнэнээр нь үзүүлэх явдал” гэж онцолж байв. Түүний “Чулуу бутлагчид” зурагт уйгагүй тэвчээртэй ажиллах хөгшин залуу хоёр чулуучин дүрсэлжээ. Настай ажилчны хөдөлгөөн хувь заяатайгаа эвлэрсэн хүнийг, хүнд чулуу өргөсөн залуугийн ядрал зүдрэлийг үзүүлнэ. Энэ

Реализмын нэрт төлөөлөгчдөөс: Францын Т.Руссо, К.Коро, Г.Курбе, Ф.Милле, О.Домье, Германы А.Менцель, В.Лейбль, Оросын Г.Г.Мясоедов, К.А.Савицкий, П.А.Федотов, В.Г.Перов, И.И.Шишкин, И.Е.Репин, В.И.Суриков, В.М.Васнецов, И.И.Левитан

Импрессионизм

1874 оны 4 сарын 15-нд Францын Парис хотноо нээгдсэн нэгэн үзэсгэлэнгийн тухай Луи Леруа “Шаривари” сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллээ К.Монегийн “Сэтгэгдэл. Өглөөний нар мандал” зургаар нэрлэсэнээс эхлэн “Импрессионизм” (фр. Impression-сэтгэгдэл) хэмээх нэр томъёо үүсчээ. Импрессионистууд уран бүтээлдээ өөрийн сэтгэгдлийг чөлөөтэй илэрхийлж, гоо сайхныг таашаан үзүүлсэн жинхэнэ урлагийг бий болгохыг тунхагласнаараа онцлог юм. Импрессионистууд цэвэр, тод, өнгүүд эгнүүлэн тавьж зурах болсон нь тодорхой зайнаас хоорондоо сүлэлдэн өнгийн харилцаа гол болж, сэдэв нь хүрээлэн байгаа орчин болсон байна. Тэд урлаг бол урлаг гээд өнгийн

цоглог аяс, эрчимт чөлөөт бичлэг, сэтгэгдлээ шууд бичиж илэрхийлдэг байснаараа реалист уламжлалд шинэчлэл хийж байв.

Импрессионизмын нэрт төлөөлөгчдөөс:

Францын К.Моне, Э.Мане, Э.Дега, О.Ренуар, К.Писсарро, А.Сислуй, Б.Моризо, О.Роден, Английн Ж.Уистлер, Германы М.Либерман, Шведийн А.Цорн, Америкийн М.Кассат

Неоимпрессионизм

Импрессионизмын цэвэр өнгөөр бичих арга барилыг шинжлэх ухааны үндэстэй шинэчлэхдээ дивизионизм (лат. Divisio – тусгаар, саланги), пуантализм (фр. Pointe - цэг) аргаар бүтээж байсан Ж.Сёра, П.Синьяк тэргүүтэй хэсэг уран бүтээлчдийг неоимпрессионистууд гэдэг. Цэвэр өнгүүдийг цэглэх, толболох аргаар түрхэж бичих нь бүтээлийг улам гэрэлтэй, агаарлаг болгодог байна. Неоимпрессионистууд аливаа зүйлийн дүрс, өнгө, зохиомжийн



Зураг 108. К.Моне. “Өглөөний нар мандалт”. 1872. Мармоттан музей. Парис

зохицолд анхаарахын зэрэгцээ орон зайн асуудлыг шинээр шийдэж, бодит зүйлээс



Зураг 109. Ж.Сёра. “Курбевуа дахь гүүр” (1886-1887). 46.4 x 55.3 см. Зотон, тос. Галерей, Лондон

“Ургуулан” авсан зохиомол дүрсийг зохиомжлох анхны оролдлого хийж байв. П.Синьякийн 1899 онд бичсэн “Эжен Делакруагаас неоимпрессионистууд хүртэл” гэсэн ном гарснаас тусдаа урсгал болсон.

Зохиогч “Хараа зүйн шинжлэх ухаанд өнгө болон өнгийн хувилбарууд хоорондоо хэрхэн холилдож харагддагийг 1886 оноос уран зурагт туршин хөгжүүлсэн зураачдыг неоимпрессионистууд гэнэ.” гэж тодорхойлсон байдаг.

Неоимпрессионизмын нэрт төлөөлөгчдөөс: Ж.Сёра, П.Синьяк, А.Кросс, Т.Риссельберг

Постимпрессионизм

П.Сезан тэргүүтэй хэсэг зураачдыг урлагийн түүхэнд импрессионистууд (лат. Post- дараа, хожуу) хэмээн нэрлэдэг. Тэд хүсч байгаа зүйлээ товч тодорхой хэллэгээр гүнзгий утга санаа илэрхийлэн зурах эрмэлзэл, өнгө будгийн цоглог зохицол, дан, цул бичлэгээрээ ялгарч байсан онцлогтой. П.Сезан "...байгаль дээрх бүх эд юмс геометрийн энгийн хэлбэрээс (гурвалжин, дөрвөлжин, тэгш өнцөгт конус, цилиндр, ромбо гэх мэт.) бүтэх тул эдгээр хэлбэрүүдийг мэдрэн эзэмшсэнээр юу хүссэнээ хийх чадвартай болно.



Зураг 110 В.Ван Гог. “Улаан усан үзмийн талбай”. 1888. Пушкиний музей. Москва

Дүрс гаргах өнгө тавих хоёрыг бие биенээс нь салгаж болохгүй, өнгө төгс зохицох тусам зураг зөв гарна, өнгө баялаг болсноор хэлбэр дээд зэргээр илэрнэ” гэж тодорхойлсон байдаг.

В.Ван Гог Улаан усан үзмийн талбай зурагтаа тэнгэрийг шаргалттал халаасан нар, улаан гал мэт төөнөх усан үзмийн талбай, халуун дулаан уур амьсгалыг дээд зэргээр илэрхийлсэн байдаг.

Постимпрессионизмын нэрт төлөөлөгчдөөс: Поль Сезан В. Ван Гог, П. Гоген, А.Тулуз-Лотрек

Символизм

Символизм (грек. Symbolon- дүрс тэмдэг, таних шинж) зүүд, зөн совин, мөрөөдөл, зөгнөл үзүүлэх чин эрмэлзэлтэй үүсчээ. Жан Моррис (1845-1903) “Фигоро” сонинд 1886 онд “Символизмийн тунхаглал” хэвлүүлснээр хөдөлгөөний нэр үүссэн.

VIII АНГИ

Символистууд бодит хэлбэрийг ягштал дагах хэрэггүй, харин хэлбэрийн цаана нуугдаж буй агуулга руу нэвтэрч, юмс үзэгдлийн үл мэдэгдэх мөн чанарыг үзүүлэх хэрэгтэй гэж үздэг. Символизмийн зорилго нь хүмүүсийн бодит байдлаас дээгүүр оньсого мэт харилцаа тухайлбал, шударга үнэн, эрх чөлөө, хүний хайр дурлал, хүсэл сонирхол, зовлон зүдгүүр, зориг эрмэлзэл зэргийг үзүүлэх явдал гэж үзэж байв.

Н.К.Рерих. Агуу их морьтон (Рэгдэндагва. Шамбалын эзэн.) зурагтаа “Монголын ард түмэн өөрийн гэрэлт ирээдүйгээ бүтээж байна. Чөлөөлөгч агуу их морьтон Монголын тал дээгүүр дүүлнэ. Их хуралдай чуулж, ардын шинэ амьдралыг шийддэг болжээ. Сайхан улаан морьтны уриа чангаас чанга сонсогдоно. Ид цэцэглэлтийнхээ үед хамгийн сайхан бэлгэнд урлагийн бүтээл, эсвэл номыг тооцож байсан Азийн сайн цаг дахин ирлээ.” гэсэн тайлбарыг хавсаргасан байна.




Зураг 111. Н.К.Рерих. “Агуу их морьтон”. 1926

Символизмийн нэрт төлөөлөгчдөөс: Н.К.Рерих, А.Беклин, Ф. Штук, Пюви де Шаванн, Г.Моро, О.Роден, В.Э.Борис-Мусатов, К.Клодель

Модерн урлаг

Модерн урлаг (modern art) нь урлагийн нэг тодорхой чиглэл бөгөөд уламжлалт гоо сайхан, гоо зүйн сэтгэлгээний хүрээнд арга барилын шинэ шийдэл гаргасан. Энэ



Зураг 112. Анри Матисс. “Улаан урлан”. 2011

нь бодит ба бодит бус дүрсүүдээр зохиомжлох, цэвэр өнгө, өнгийн хувьсал болон бүтээлийн хэмнэл орон зайг алслалт хэрэглэхгүйгээр гаргах зэрэг шинэлэг арга нэвтрүүлсэн. Модерн – шинэ урлаг 1870-аад оны үед Францад гарсан импрессионизм гэх урсгалаас эхтэй гэж үздэг. Модерн урлаг нь классицизм дахь дүрслэлийн хууль, дүрэм, зарчмуудыг хэрэгсэхгүйгээр бодит ба бодит бус дүрслэлээр чөлөөтэй сэтгэж дүрслэх боломж олгодог. XIX зууны төгсгөлд үүссэн фовизм, кубизм, футуризм, абстракционизм зэрэг дүрслэх урлагийн чиглэл,

урсгалуудыг нэгтгэн модерн гэнэ. Модернистууд урлагийг үндсээр нь шинэчлэхийг эрмэлзэж, хийсвэр сэтгэлгээний шинэ арга ухааныг эрж хайсаар ирсэн түүхтэй.

А.Матиссын “Улаан урлан” хэмээх зургийн өрөөний хана нь час улаан бөгөөд түүний доторх ширээ, сандал, хананд зураг өлгөөстэй байна. А.Матисс энэ зурагтаа алслалт гэх академик онол, арга хэрэглээгүй бөгөөд өнгө дүрсийн харьцаа, зохиомж зэргээр орон зайн мэдрэмжийг үзүүлж чадсан юм. Зурагт харагдаж байгаа ширээний өнцөг орон зай илэрхийлэх зохиомжийн чухал үүрэг гүйцэтгэжээ.

Модерн урлагийн нэрт төлөөлөгчдөөс: Винсент Ван Гог, Поль Гоген, Анри Матисс, Пабло Пикассо, Амедео Модильяни.

Фовизм

1905 онд Парис хотноо францын “les fauves” буюу “Зэрлэгүүд” гэж хочлогдсон 12 зураач бүтээлээ “Салон” үзэсгэлэнд дэлгэн үзүүлсэн байна. Судлаач Э.Х.Гомбрих бичихдээ: “Зургуудынх нь өнгө будгийн зэрлэг догшин байдал зохих хэлбэр дүрсүүдийг нь дарж байснаас тэд ийм хочтой болсон ажээ. Үнэн хэрэгтээ тэдгээрт зэрлэг догшин зүйл тун бага байв.” [Гомбрих Э.Х.(2010). Урлагийн түүх] гэсэн байлаа. Ийнхүү өнгийн “Тэсрэлт” дээр үндэслэсэн фовизм хэмээх урсгал ХХ зуунд урлагийн анхны хувьсал болсон гэдэг. Фовистууд академик онолын арга барилыг баримтлахгүйгээр өөр аргаар ч гэсэн хүмүүс болон юмс, үзэгдлийг дүрсэлж болдгийг үзүүлжээ. Фовизмын түүх 1905 оноос эхлээд, ид цэцэглэлтийн үе нь 1907 он байв.

Улаан ханатай өрөөнд хээ угалзтай, улаан бүтээлгээр бүтээсэн ширээн дээр эмэгтэй алим жимс өрж байна. Цонхоор дугуй хэлбэр дүрстэй модод харагдах нь өрөөний дугуйрсан хээ угалзтай зохицно. Өрөөн доторх хүнд өнгөөс гадаад орчныг цайвар өнгөөр ялгасан нь алслалтыг орлон орон зай илэрхийлэх Матисын арга юм. Хурц тод өнгийн хавтгайнууд, ерөнхий шинж маягтай хэлбэр дүрсүүд нь Матисын онцгой эрхэмлэдэг чамин ур хийц, янз маягийг харуулж байгаа юм.



Зураг 113. Анри Матис. “Улаан өрөө”.
1908. 180x220 см. Зотон, тос

Фовизм нэрт төлөөлөгчдөөс: Анри Матисс, А. Марке, Ж. Руо, А. Дерен, М. Вламинк, Р.Дюжи, К. Ван Донген

Кубизм

Кубизмын урсгалыг 1907 онд Испанийн Пабло Пикассо, Францын Жорж Брак нар үндэслэсэн гэдэг. Кубистууд ертөнцийн бүх биетийг геометрийн хэлбэр дүрсүүдээр зохиомжлон орон зай, агуулгыг илэрхийлж болно гэж үздэг.

П.Пикассо 1907 онд “Авиньоны хүүхнүүд” зурагт хүүхнүүдийг зурахдаа геометрийн хэлбэр дүрс ашигласан учир судлаачид шинэ урсгал хэмээгээд “Кубизм” гэж нэрлэжээ. Бүх юм геометрийн дүрсээс бүтдэг гэсэн санааг Поль Сезан анх гаргаж, “Гэгээн Виктуар уул” гэдэг зургаа 1904 онд зурчихсан байв. Кубистууд элементүүдээс хэлбэр дүрс бүтээх аргатай байсан. Кубизмд хэлбэр дүрсийг задлах асуудал чухал бөгөөд юмсыг гадна, дотор, хажуугаас нь гэх зэрэг олон өнцгөөс нэгэн зэрэг харж, орон зай илэрхийлдэг нь шинэ арга байв. Кубизмын урсгал 1907-1914 онд эрчимтэй хөгжсөн байдаг.



Зураг 114. Пабло Пикассо.
“Авиньоны хүүхнүүд”. 1907

Кубизмын нэрт төлөөлөгчдөөс: П.Пикассо, Ж.Брак, К.С.Малевич, В.Е.Татлинн

Абстракт урлаг

Абстракционизм (лат. Abstraction -хийсвэрлэх)-ийг урлаг судлаачид “Бодит бус дүрслэлийн урлаг” гэж нэрлэдэг. Эртний хүмүүс хэрхэн хийсвэрлэн сэтгэдэг байсныг “Хад”-ны зургаас харж болно. Хийсвэр сэтгэлгээ илэрхийллийн арга болгон онол боловсруулсан нь XX зууны эхэн юм. Оросын зураач Василий Кандинский (1866-1944) абстракт урлаг ба онол бий болгосон гэж үздэг. 1911 онд Германд хэвлэгдсэн

Кандинскийн “Урлаг дахь дотоод сэтгэлийн тухай” хэмээх ном нь абстракт урлагийн гол бүтээлүүдийн нэг юм. Кандинскийн үзэж байгаагаар дүрс, өнгө болгон өөрийн дотоод агуулгатай, хүнд нөлөөлөх чадвартай байдаг бөгөөд аливаа дүрс өнгөтэй болоход түүний нөлөөлөл өөрчлөгддөг гэнэ. Тэрээр өнгө болгон өөрийн өгүүлэмжтэйг нэг бүрчлэн судалж, хөгжим, байгаль орчинтой харьцуулан тайлбарласан байдаг. Хэлбэр дүрсүүд ч тодорхой сэтгэгдэл төрүүлдэг бөгөөд өнгөтэй хослон өнгийн чадлыг идэвхжүүлдэг



Зураг 116. Василий Кандинский
“Сэлүүрдэлт” 1912. 97x108 см. Зотон, тос

гэсэн байна. Абстракционизм нь модернизмын нэг урсгал бөгөөд 1910-аад онд үүссэн гэдэг.

В.Кандинский Импровизац 26 буюу Сэлүүрдэлт зургаа 1912 онд зуржээ. Сэлүүрдэлт зургийн далд гол санаа: Зургийг сайн ажиглавал хэд хэдэн өгүүлэмжтэй байна. Улаан муруй зураасуудаар завь дүрсэлсэн байж болно. Хар зураасууд бол завин дотор суугаад урт бараан сэлүүрээр сэлүүрдэж байгаа хоёр хүнийг харуулж байна. Завь ширүүндүү урсгалтай, өнгө бүхий эрчимтэй давлагаан дундуур хөвж явааг илтгэнэ. Түүний дээгүүр шувуу шиг хар дүрс тэнгэрт нисэж яваа мэт үзэгдэх ажээ.

Абстракционизмын нэрт төлөөлөгчдөөс:

В.Кандинский, П.Мондриан, Р.Делоне, К.С.Малевич, Марк Ротко, Жексон Поллок, Вильем де Кунинг

Сюрреализм

(фр. Surrealist) – сюрреализм sur- сюр- дээр, реализм- бодит байдал, энэ нь бодит байдал дээр бодит байдал гэсэн санаа юм. Сюрреализмд Австрийн сэтгэл зүйч Зигмунд Фрейдийн хүний сэтгэл зүйн талаарх нээлт хүчтэй нөлөөлсөн гэж үздэг. Зураач Макс Эрнст “Сюрреализмын уран зургийн онол” хэмээх бүтээлдээ “Сюрреалист хэмээн нэрлэгдсэн уран бүтээлд ухамсар, шалтгаан, таашаал, хүсэл бодол зэрэг ойлголт байхгүй.”



Зураг 117. Салвадор Дали. “Далайн эргийн элсэн дээрх жимсний савнаас хүний нүүр тодрох нь”. 1938. 114.2 x 143.7 см. Зотон, тос

гэсэн байв. Зохиолч, яруу найрагч Андре Бретон “Миний хувьд сюрреалист дүрслэл нь хамгийн санаанд оромгүй байдлаас төрснийг хэлэх ба хамгийн зохицолгүй, ... хий үзэгдлээс төрсөн юм шиг, жирийн физикийн хууль огт үйлчилдэггүй, инээдэмтэй ч байж магад, энгийн хэлээр тайлбарлахад хамгийн хэцүү бүтээл байх болно” гэж хэлсэн байдаг. Урлаг судлаачид сюрреализмыг тодорхойлохдоо: “Сюрреалист уран бүтээлд логик санаа гэж байхгүй, айсан, цочирдсон, гайхсан, зүүдэлсэн, хий үзэгдэл харсан, гэнэтийн тохиолдлын гэх мэт байдлуудад төрсөн сэтгэгдлийг дүрсэлдэг” гэсэн байна. Сюрреализмын анхны үзэсгэлэн 1925 онд Парист нээгдэж байв.

Судлаач Э.Х. Гомбрих, Салвадор Далийн “Далайн эргийн элсэн дээрх жимсний савнаас хүний нүүр тодрох нь” зургийг тайлбарлан бичихдээ: “Зохиомжийг сайн ажиглавал баруун дээд булан дахь хачин жигтэйхэн байгаль буюу давалгаа хаялсан тэнгисийн булан, нэвт гарсан хонгил бүхий уул, хүзүүвч нь тэнгис дээгүүр

VIII АНГИ

дамнасан төмөр замын гүүр болж харагдах нохойны толгой руу эвхэгдэн орж байна. Энэ нохой хий үзэгдэл мэт агаарт жингүйдсэн байх ба биеийнх нь дунд хэсэг өөрөө эмэгтэй хүний нүүр болж харагдах жимстэй савыг үүсгэжээ. Эл эмэгтэй, тэнүүлч хий үзэгдлүүдийн наран шарлагын энэхүү талбайгаас үсрэн зайлж байгаа дун хорхой нүдээрээ биднийг эгцлэн ширтэнэ” гэсэн байдаг.

Сюрреализмын нэрт төлөөлөгчдөөс: Испанийн Сальвадор Дали, Хуан Миро, Германы Макс Эрнест, Италийн Георгио де Чирико, Бельгийн Рол Дельвекс, Францын Андре Массон



Уран зургийн цуглуулгын сантай болж, дагнасан бүтээлийн цуглуулга хийж болох юм. Тухайлбал, “Модерн зургууд” эсвэл “Монгол зургууд” гэх мэт.

Хүснэгт 10. Уран зургийн онцлогийг бичих

	Чиглэл, урсгал	Гол онцлогийг 2-3 өгүүлбэрээр илэрхийлэн бичнэ.
1.	Классицизм	
2.	Импрессионизм	
3.	Символизм	
4.	Абстрак урлаг	
5.	Сюрреализм	

Хүснэгт 11. Нэрт уран зураачид нь аль чиглэл урсгалд голлон хамаарахыг холбон зурж үзүүлнэ.

Реализм	Анри Матисс, Ж. Руо
Постимпрессионизм	О.Домье, Ф.Милле, В.Г.Перов
Фовизм	Поль Сезан, В.Ван Гог
Импрессионизм	Пабло Пикассо, Поль Гоген
Модерн урлаг	Э.Мане, Э.Дега, К.Писсарро



Дүрслэх урлагийн чиг хандлагын онцлог юу вэ гэдгийг мэдэх, тус бүрдээ ямар ач холбогдол, арга дэвшилтэй байсныг ярилцана.

МОНГОЛЫН ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН БҮТЭЭЛТЭЙ ТАНИЛЦАХ



Монгол Улсын Ардын зураачдын тухай ярилцах

1: Уран зургийн гол ба туслах дүрээр дамжуулан агуулга, уран дүрслэлийг ойлгох



Уран зургуудыг сонирхон судалж, харилцан санаа бодлоо илэрхийлнэ.

- Зураг дээр юу зурсныг тоочих
- Зохиомжийн гол ба туслах дүрийг зургийн аль хэсэгт хэрхэн байрлуулсныг тодорхойлох
- Тухайн зурагт задгай, сүрлэг бадрангуй, жишүү, нэг төвт зохиомжийн арга орсон эсэхийг мэдэх
- Зураач, зургийн гол агуулгыг хэрхэн илэрхийлснийг мэдэх
- Харааны түвшний шугам зургийн хавтгайн хаагуур байгааг баримжаалах
- Алслалтын онол хэрхэн дүрслэгдсэнийг хэлнэ.
- Зургийн өнгө зохицлыг өөрийн бодлоор тодорхойлох
- Тухайн зургийн талаарх сэтгэгдлээ хэлэх

				
<p>Хөдөлмөрийн баатар, Ардын зураач Ням-Осорын Цүлтэм (1923-2001)</p>	<p>Ардын зураач, Төрийн шагналт Үржингийн Ядамсүрэн (1905-1986)</p>	<p>Ардын зураач, Төрийн хошой шагналт Очирын Цэвэгжав (1915-1975)</p>	<p>Ардын зураач, Төрийн шагналт Лувсангийн Гаваа (1920-1991)</p>	<p>Ардын зураач, Төрийн шагналт Гэлэгийн Одон (1925-1996)</p>
 <p>“Уриа” 1972, тос зотон</p>	 <p>Өвгөн хуурч 1958</p>	 <p>Эмнэг сургагч 1952</p>	 <p>Кино механикч. 1963, зотон, тос</p>	 <p>Ажлын дараа, 1952, зотон, тос</p>

				
Ардын зураач, Төрийн шагналт Лувсаншаравын Намхайцэрэн (1913-1992)	Ардын зураач, Төрийн шагналт Дагдангийн Амгалан (1933- 2009)	Ардын зураач, Адьяагийн Сэнгэцохио (1917-1986)	Ардын зураач, Балбарын Гомбосүрэн (1930-2000)	Ардын зураач, Төрийн шагналт Нямын Жамбаа (1910-1998)
				
Шуурга. 1961	Жаахан шаргын нутаг. 1965. Зотон, тос	Ленинд бараалхсан нь 1967. Зотон, тос	Борооны дараа 1987. Зотон, тос	Айраг. 1960
				
Ардын зураач, Чойжилжавын Гунгаасүх (1944)	Ардын зураач, Лэгжидийн Чуваамид (1934-2011)	Ардын зураач, Цэрэнжавын Доржпалам (1923-2008)	Ардын зураач, Б.Чогсом (1930-)	Ардын зураач, төрийн шагналт До.Болд, (1952)
				
Спартак балет, бүжгийн жүжиг 2013	Хээ угалз. Модон сийлбэр 1976	Хад. Усан будаг 1962	Говь. 1967	Боорчи мину зээ, 2010. Зотон тос

Зураг 118 Монгол улсын ардын зураачид

Зөвлөмж: Ардын зураачдын зургийг бүтээлийн хамт танилцуулж ярилцана.

2. Уран зураг унших

Үүний дараа Б.Шаравын “Балдан гачин” монгол зураг эхлэн бичигдэнэ.

Балдуугийн Шаравын “Балдан гачин” монгол зураг



Зураг 119.

Б.Шарав “Балдан гачин”
XX зууны эхэн

Б.Шаравын зургийн анхны багш нь Жанцан гэдэг хүн байсан аж. Тэрээр бүтээлийн ажлаа ардын урлалын монгол хөзөр, үйчүүр, хээ угалз, домгийн сэдэвт зургаар эхэлсэн гэдэг. Хүрээнд ирээд зураач Д.Гэндэндамбад шавь оржээ. Б.Шарав гачин ламын хашаанд илүү гэрт нь амьдран, зургаа зурдаг байжээ. “Балдан гачин” хөрөг зурахдаа туслах дүргүй, зөвхөн гол дүр дээрээ анхааран ажилласан байдаг. Энэ нь хүний дотоод сэтгэлгээгээр уран сайхны дүр илэрхийлэх шинэ зарчим баримталсан асуудал байлаа. Учир нь туслах дүр тухайн бүтээлийн агуулгыг илэрхийлэхэд чухал үүрэгтэй байдаг боловч энэ зурагт түүнийг хэрэглээгүй, дүрээр дамжуулан агуулгаа илэрхийлжээ. Энэ хөрөгт нэг өнгийн тоноор орон зайг чадамгай шийдэж, бөс даавууны нугалаа атирааг уран гаргаж, биет юмсын бодит чанарыг үзүүлж чадсан байдаг. Манай зураачид ихэвчлэн хүнд өнгөөс хөнгөн рүү, товгор

хэсэгт нь хүнд өнгө тавьж зурдаг байсан бол Б.Шарав товгор хэсэгт нь хөнгөн өнгө тавьж, гэрэл сүүдэрт шилжүүлэн шинэ аргаар хөгжүүлэх эхлэл тавьсан байдаг.

Ням-Осорын Цүлтэмийн “Талын айл” уран зураг

Хөдөлмөрийн баатар, төрийн шагналт ардын зураач Н.Цүлтэм 1923 онд Архангай аймгийн Өндөр улаан суманд төрсөн. 1951 онд Москва хотноо В.И.Суриковын нэрэмжит уран зургийн дээд сургууль төгсчээ. Зураач “Талын айл” зурагтаа монголын хөдөө нутгийн амьдралын хэв шинжийг үзүүлсэн. Зургийн хавтгайд харааны түвшний шугамыг доогуур авч гуравны хоёрт уудам хөх тэнгэр, үлдсэн хэсэгт нарлаг сайхан өдөр тэмээ бэлчиж, машин давхин, алс холын айлыг хоттой холбох дардан зам зурайж байгаа зэрэг амьдралын энгийн зүйлсийг орон зайн алслалттай дүрсэлсэн байна. Таана, хармагийн сайхан үнэр ханхалсан ногоон талын төв хэсэгт хоёр тэмээ сүртэйхэн харагдаж, түүний цаагуур хот айл алслан үзэгдэнэ. Энэхүү зурагт дүрсэлсэн юм бүхэн цаанаа тодорхой зорилго чиглэлтэй амьдралын утга учиртай агуулга илэрхийлнэ.



Зураг 120. Н. Цүлтэм “Талын айл” 1955. Зотон, тос

Үржингийн Ядамсүрэнгийн “Өвгөн хуурч” монгол зураг



Зураг 121. “Өвгөн хуурч” 1958,
80x60 см

Ардын зураач Ү.Ядамсүрэн Дорнод аймгийн Түмэндэлгэр суманд 1905 онд төржээ. Тэрээр “Өвгөн хуурч” зургийн дүрээр ард түмнийхээ сэтгэл оюун, хүсэл мөрөөдөл, зан заншил, монгол төрхийг дүрсэлжээ. Ү.Ядамсүрэн энэ зургаа монгол зургийн урлах аргаар чадамгай зурсан юм. Монгол уламжлалт урлах ухааны “Цагаан, шар, улаан, ногоон, хөх” гэсэн таван үндсэн өнгийг ашиглан монгол үндэсний өнгө эрхэмлэн хүндэтгэх ёсонд нийцүүлэн зурсан байна. Хуурч өвгөний дээл хувцсыг угсаатны зүйн ёс горимоор дүрсэлж, монголчуудын эрхэмлэдэг хээ угалз шигтгэн зурсан. “Өвгөн хуурч” зурагт монгол зургийн бэлгэдэл, дүрслэл, хурц тод өнгийн зохирол эрэмбийг европ зургийн алслалттай (Олбог, морин хуур гэх мэт.) зохицуулан зохиомжлон зурсан байна. Эрдэмтэн С.Лувсанвандан Монголын урлагийн уламжлал шинэчлэл номдоо: Амьдралын үнэн, зураачийн уран сэтгэмж, дүрийн нийгэм, гоо

зүйн болон гоо сайхны үндэслэл Ү.Ядамсүрэнгийн “Өвгөн хуурч” хөргийн том ололт мөн гэж тэмдэглэжээ.

Очирын Цэвэгжавын “Азарганы ноцолдоон” уран зураг

Ардын зураач, төрийн хошой шагналт О.Цэвэгжав Буриад АССР-ийн нутагт 1915 онд төржээ. “Азарганы ноцолдоон” зургаа 15 жил бодож, боловсруулан зурсан гэдэг. Зургийн зүүн төв хэсэгт ноцолдож байгаа хоёр азарга байрлуулж, зүүн баруун хоёрт нь адуун сүрэг зурж, баруун талын алсад гэр сүүмэлзэн харагдаж, тэндээс уурга



Зураг 122. О.Цэвэгжав “Азарганы ноцолдоон” 1958.Зотон,
тос. 147x200 см

барьсан адуучин залуу ноцолдсон хоёр азаргын зүг давхиж буйгаар зуржээ. Хар хээр ба шарга азаргын зүсийг эсрэгцүүлж, энэ хоёрын тэмцлийн санааг өнгийн зохиомжоор илэрхийлсэн. Мөн нарны шаргал туяаг ноцолдож байгаа хоёр азаргын цээжин хэсэгт тусаж буйгаар өнгийн эсрэгцэл оруулан зурсан нь хөдөлгөөний эрч хүч, сүрлэг байдал, тэмцлийг нэмэгдүүлсэн арга болжээ. Хээр азаргын хөлийг шийр алаг зурснаар тулах цэгийг тодруулж, шарга азаргыг сартай зурж толгой хэсгийг ялгаралд чухал нөлөө үзүүлэхээр болсон байна. Зураач харааны түвшний шугамыг доогуур авсан нь сүрлэг бадрангуй дүрийн зохиомж болсон байна.

Дагдангийн Амгалангийн “Жаахан шаргын нутагт” уран зураг

Ардын зураач Амгалан 1933 онд Сүхбаатар аймгийн Хонгор суманд төржээ. “Жаахан шаргын нутагт” зурагт харааны түвшний шугамыг дээгүүр буюу газрыг зургийн хавтгайн бараг тавны дөрөвт нь авч гол ба туслах дүрүүдээ байрлуулсан. Зураач гол дүрээ томоор авч тод улаан дээл өмсгөсөн нь сүрлэг сайхан харагдана.



Зураг 123. Дагдангийн Амгалан. “Жаахан шаргын нутагт”. 1965

Урлагийн тоглолтыг тэсч ядан хүсэн хүлээдэг хүүхдүүд гэрийн сүүдэрт баяр хөөртэй байх агшин, морин хуурч, малчинтай хууч хөөрөх зураглал, алслан харагдах айл хөршийн амьдралаар туслах дүрийг тодруулжээ. Нохой гаслам халуун нарыг номин ногоон талд эгц дээрээс тусган, улаан ногоон эсрэг өнгө харшуулан зурсан нь өнгийн зохиомж, ялгарлын сайхан жишээ болсон. Байгалийн болон урлагийн сайхан хоёроор амьдралын тансаг агшинг зураач үзүүлж чадсан байна.



Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлтэй танилцан өөрсдийн сэтгэгдлээ ярилцах

3. Монголын орчин үеийн дүрслэх урлагийн бүтээлтэй танилцах, унших.



Зураг 124. Л.Бумандорж.
“Зохиомж”. 2009. 100x200см.
Зотон, тос



Зураг 125.
Э.Болортүвшин. “Ийм байсан юм”. 2011.
120x100. Зотон тос



Зураг 126. Т.Нурмаажав.
“Сэтгэлд мандсан нар”. 2014
150x100. Гуаш, даавуу



Аливаа үйлд эх оронч сэтгэлээр ханддаг дүрийг илтгэсэн бөгөөд амьдралын хатуу ширүүнийг биеэрээ бага наснаасаа туулж, сэтгэл зүрхээ эх орон ард түмэндээ зориулсан Тэмүүжин хүүгийн дүрийг харуулжээ. Зургийн хавтгайд харааны түвшний шулууныг харааны түвшинд авсан нь гол дүрийг сүрлэг сайхан дүр болгож чадсан байна. Өнгийн эрс тэс ялгарлыг чадварлаг ашиглаж, гол дүрслэлийг тод өнгөөр цаана байгаа туслах дүрүүдийг бүдэг өнгөөр ерөнхийлөн зурсан нь зургийг сайхан болгожээ. Зураач бүтээлээ бор ногоон өнгөөр зурсан нь Тэмүүжин хүүгийн дотоод сэтгэл галтай цогтой, дайчин эрэлхэг эх орноо гэсэн зан байдлыг гадна талдаа даруухан, тайван сэтгэлийг илэрхийлжээ.



Зураг 127 Д. Булгантуяа. “Тэмүүжин”. 2006. 180x120 см. Зотон, тос

Зураач Ц.Эрдэнэцог XX зууны Монголын түүхийн онцлох үйл явдлыг харуулсан “Бат-Оршил”, “Цэргүүд ирлээ”, “Ялалтын мэдээ”, “36-гийн 27” зэрэг цуврал уран зургийн бүтээлүүдийг туурвисан юм.

Зураачийн Үндэсний ардчилсан хувьсгалаас эхлэн социализмыг байгуулж байсан үеийн нийгмийн амьдралыг үзүүлсэн “Нэгэн цагт”, “Тусгал” цуврал зургуудад Ардын хувьсгалын үеийн амьдрал, эх орны дайны хүнд хэцүү цагийн байдал, соёлын хувьсгал, атар газар эзэмшиж, нэгдэлжих хөдөлгөөн өрнүүлж, соц-орнуудтай хамт социализм байгуулалцаж явсан тэр л цаг үед тохиолдсон онцлох үйл явдлуудыг зургийн дэвсгэрт дээр хослол зургийн аргаар зохиомжилж харуулсан сонин шийдэлтэй бүтээлүүд туурвижээ.

Зураачийн “Ялалтын мэдээ” (2015) бүтээлд дайнтай жилийн нэгэн өдөр дайсан бууж өгч, энх цаг ирсэн баярт мэдээ сонсоод сумын захиргааны өмнө цугларсан ард иргэд, хөгшид, хүүхэд бүгдээрээ хөөр баяр болцгоож байгаа тэр л агшинг үзүүлжээ. Энэ бүтээл нь суурь уран зургийн бүтээл юм.



Зураг 128. Ц.Эрдэнэцог. “Ялалтын мэдээ”. 2015.
140x150, зотон тос



Зураг 129. Ц.Эрдэнэцог. Гэрэлт ирээдүй... “Тусгал”
цуврал, 12-3, 2012. 120x150, зотон тос



Зураг 130. С.Саранцацралт. “Сансрын хүлээснээс чөлөөлөгдөхүй”.
2005. Зотон, тос

Зураач С.Саранцацралтын бүтээлүүдээс сэтгэлгээний эрх чөлөөний мэдрэмж, бясалгалын гүн гүнзгий хаялга харагддаг бөгөөд тэр бүхэн нийлээд гоо сайхны өвөрмөц хийгээд өөр ертөнцийг бүтээдэг. Сэтгэл гэдэг нүдэнд харагдахгүй гарт баригдахгүй атал гэрлийн хурдаар хэмжигддэг боломж нь хязгааргүй хэрнээ мөнхөд өөрчлөгдөж байдаг гүн ухааны ойлголт юм. Хүн сайн юм бодож байж бие сэтгэлийн эрч хүчээ авч, зөв амьдарч, аливаа сэтгэлийн хүлээснээс чөлөөлөгддөг.



Зураг 131. Л.Бумандорж. 1954. “Дэнжийн мянга”. 2002. 100x200. Зотон тос

Л.Бумандорж сүүлийн жилүүдэд их хот тэр дундаа нийслэлийн гэр хорооллын талаарх дорвитой бүтээлүүд туурвих болсны нэг нь энэхүү “Дэнжийн мянга” бүтээл юм. Хотын захын гэр хорооллын амьдралаас сэдэвлэсэн цуврал зургууд нь цэвэр өнгүүдийн хоршил, донж, дүрсүүдээрээ, дүр байдлын илэрхийллээрээ гэрэл, сүүдрийн хувьд шинэлэг арга барилаар туурвисан нь өвөрмөц онцлогтой болжээ. Хэдэн мянганы тэртээгээс эсгий гэртээ амьдран суусаар ирсэн Монголчуудын өнөөгийн суурин амьдрал, гэр хорооллын хэсгийг зураач тодоор дүрсэлжээ.



Зураг 132. Б.Насанцэнгэл. “Алтан лийр”. 2010. 90x70 см. Зотон, тос

Зураач Б.Насанцэнгэл энэ бүтээлдээ орчлон ертөнцийг бодлын тунгалаг гэгээн орон зайд өөрийнхөөрөө ойлгохыг хичээн бясалган бодлогоширч суугаа залуу бүсгүйг дүрсэлжээ. Шинжлэх ухаан техникийн дэвшлийг дагаад хүмүүс материаллаг ертөнцийг шүтэх нь илүүтэй байсан бол одоо үед арай оюунлаг хэсэг нь далд ертөнц дотоод сэтгэл рүүгээ өнгийн харж, амьдралын хэв маяг, байгаль дэлхий, ан амьтанд хандах хандлагаа эергээр өөрчилж, гэгээрэл рүү тэмүүлэх болжээ.



Зураг 133. Ц.Цэгмэд. “Жингийн цуваа”. 2009.
53x72 см. Зотон, тос

Зураач Ц.Цэгмид “Жингийн цуваа” бүтээлдээ элсэн манхны үзэсгэлэнт байгалийн өнгө төрхийг уран сайхнаар хэтрүүлэн баяжуулж, цоглог хурц өнгүүдээр амилуулан өгчээ. Зурагт хурц шар өнгөөр элсэн толгодуудыг бичиж, цул хөхөмдөг өнгөөр сүүдрийг тэмдэглэсэн байна. Монгол зургийн аргаар туурвисан түүний зургуудад талын монгол айлын өдөр тутмын амьдрал, нүүдэлчдийн ахуй, байгалийн гоо сайхан үзэгддэг. Тайван үргэлжлэх тэр хэмнэл нь ер бусын

тайван бөгөөд сэтгэл татам гоо сайхан, баяр баяслаар дүүрэн санагдах сэтгэгдлийг төрүүлнэ.

Зураач Т.Нурмаажавын “Хайрын бурхан” зурагт жигдрэн ургасан торгон ногоон зүлэг, гоёмсог цэцгийн мандал дээр аянгат ширүүн борооноос хүүхдээ хамгаалж, баруун гартаа шүхэр барьсан эхийн сэтгэл нь эх үрсийн ариун нандин холбоо хайр энэрлийг бэлгэджээ. Зураач зургандаа эхийн дүрийг тод улаан буюу дулаан өнгөөр авч, туслах хэсэгт хүйтэн өнгө голлон авсан нь дүрийн ялгарал агаарлаг чамин сайхан цэмцгэр байдлыг илэрхийлжээ.



Зураг 134
Т. Нурмаажав. 1976. “Хайрын бурхан”.
2014. 80x50 см. Даавуу, гуаш



Зураг 135.
Д.Эрдэнэбилэг. “Нутгийн бараа”.
2010. 90x70 см. Зотон, тос

Зураач бүтээлдээ нүүдэлчин амьдралын онцлогийг харуулсан байна. Зургийн хавтгайн төв хэсэгт зургийн гол дүр болох нүүдэлчин эрийн дүрийг тод томруун дүрсэлжээ. Зураач харааны түвшний шугамыг доогуур авч гол дүрслэлийг дүүрэн авснаар сүрлэг бадрангуй дүр гаргаж чадсан байна. Зураач дулаан, хүйтэн өнгийн шүтэлцээ, эрс тэсийн ялгарлыг чадварлаг ашиглаж чаджээ.



Өөрсдийн зурсан сэдэвт зураг дээр гол дүрээр ямар утга санааг үзүүлэхээр зурснаа жишээлэн ярилцах. Мэргэжлийн зураач, урлаг судлаач, уран бүтээлчидтэй ярилцлага зохион байгуулах

Цахим хаяг:

1. www.uma.mn
2. www.slideshare.mn
3. www.wikipedia.mn
4. <https://www.google.mn/search?q=Malevich+Composition&espv=2&biw=1920>
5. www.studentartguide.com
6. <http://mn.wikipedia.org/wiki/>
7. <http://en.wikipedia.org/wiki/utamaro>
8. www.zanabazarfam.mn
9. www.buzan.org

НОМ ЗҮЙ

1. Баярмаа Ч. Эрдэнэтогтох Г. (2009), Монгол ардын хээ угалз. Улаанбаатар
2. Баяртөр Б. (2001). Аж байдлын монгол зураг. Улаанбаатар
3. Баярмагнай З. (2013) “Дүрслэх урлагийн хичээлээр сурагчдын зохиомжлох үйлийн баримжааг хөгжүүлэх арга зүй”. Улаанбаатар
4. Батчулуун Л. Жүнш С.(2011), Урлах ухааны нууц. Улаанбаатар
5. Батчулуун С. нар. (2011) Дүрслэх урлагийн боловсрол. Улаанбаатар
6. Бьюзан Т, Бьюзан Б. (2005), Оюуны зураглал. Улаанбаатар
7. Гомбрих Э.Х. (2010), Урлагийн түүх
8. Даваахүү С. (2007), Уураг тархи ба шинжлэх ухаан.Улаанбаатар
9. Дулам С. (2007), Монгол бэлгэдэл зүй. IVботь. Улаанбаатар
10. Дэлгэрмаа Б. (2002), Урлаг ба танин мэдэхүйн онолын харилцааны асуудал. Нэг сэдэвт зохиол.Улаанбаатар
11. Лхагва А. (2009), Монгол зураачид.Улаанбаатар
12. Манибадар Д. (2012), Монгол үндэсний хээ угалз.Улаанбаатар
13. Одон, Г нар. (1988). Хар зураг. Улаанбаатар
14. Ребекка Лионс, Эмили Шрайнер нар – зөвлөх, (2010). Урлаг хүүхдийн ном. Улаанбаатар
15. Роза Дикинс. (2015), Уран зураг, хүүхдийн ном. Улаанбаатар
16. Уранчимэг Ц.(2002). XX зууны өрнөдийн урлаг. Улаанбаатар
17. Питер Грэй (2007). Уран зураг ба дүрслэх урлагийн сурах бичиг. Улаанбаатар
18. Пүрэвбат Г. (2013). Ярилцлага, илтгэлийн эмхэтгэл. I, II дэвтэр.Улаанбаатар
19. Содномцэрэн, Х. (2013). Уран бүтээлч болох замд. Улаанбаатар
20. Сономцэрэн Л. (1987). Дүрслэх урлагийн онол, түүхийн асуудлууд. Улаанбаатар
21. Сосор О.(2010). XIX зууны урлаг. Улаанбаатар
22. Төмөрбат Ж. (2013) “Зохиомж өнгө, хэлбэр, гоо сайхан”. Улаанбаатар
23. Цэдэн-Иш Д. (2011). Дүрслэх урлагийн багшийн ном.Улаанбаатар
24. Шүгэр Ц. (1991). Монгол модон бар. Улаанбаатар
25. Энхдаваа Д.(2001). Монгол хээ чимэг.Улаанбаатар
26. Эрика Лангмуйр зөвлөх (2014). Уран зураг хүүхдийн ном. Улаанбаатар
27. Эрдэнэцог Ц.(1999). Уран зургийн өнгө.Улаанбаатар
28. Эрдэнэцог Ц. нар (2015). Дүрслэн урлахуйн үндэс. Улаанбаатар

ДҮРСЛЭХ УРЛАГ VIII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
8 дугаар ангийн сурах бичиг

Зохиогчийн баг

Ахлагч:	Д.Цэдэн-Иш
Гишүүд:	А.Ариунболд
	Б.Баттулга
	С.Батцоож
	З.Баярмагнай
	Б.Галбадрах
	Х.Доосүрэн

Редактор:	Ц.Эрдэнэцог
Техник редактор:	Б.Баярцэцэг
Зураач:	Ц.Мөнхмандах
Хэвлэлийн эх бэлтгэгч:	Г.Гариг

Хэвлэлийн дизайнер:	Г.Ганчимэг
---------------------	------------

Формат 70x100/16
Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80гр/м²
Хэвлэлийн хуудас 7.8 х.х

Хэвлэлийн эхийг “Адмон принт” ХХК-д бэлтгэж,
“Мөнхийн Үсэг ХХК”-д 31000 хувь хэвлэв.